



СОЁМБО



БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТӨВ ХЭВЛЭЛ

2020.12.03 №47 (10724)

Үнэ 500 төгрөг

Дугаар эрхэлсэн хошууч Д.ОЮУНГЭРЭЛ

ЦЭРГИЙН СУРГАЛТ БЭЛТГЭЛИЙН ТОГТОЛЦООГ ШИНЭЧИЛСЭН ЖИЛ БОЛНО

Зэвсэгт хүчний 2020-2021 оны сургуулийн жилийн нээлтийн үеэр Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хошууч генерал Д.ГАНЗОРИГИЙН хэлсэн үгийг бүрэн эхээр нь хүргэж байна.

Эрхэм генерал, офицерууд, ахлагч, түрүүч, байлдагч, цэргийн гэрээт алба хаагчид Та бүхэнд Зэвсэгт хүчний 2020-2021 оны сургуулийн жилийн мэндийг дэвшүүлэе!

Өнгөрсөн сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлээр Зэвсэгт хүчин улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтад оролцох болон дэлхий нийтэд үүссэн цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөлтөд тодотгол хийж, хэрэгжилтийг нь хангуулан, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Төрлийн цэргийн командлал, нэгтгэл, анги, байгууллага, салбар бүр сургалтын төлөвлөгөөний дагуу сургалт бэлтгэлийг тасралтгүй явуулснаар дэвшүүлсэн зорилго, зорилтоо бүрэн хангалаа.

Түүнчлэн "Зэвсэгт хүчний штабын бэлтгэл сургалтаар тэргүүлэгч штабыг шалгаруулах бэлэн байдлын

үзлэг"-ийг чанартай явуулсан, Зэвсэгт хүчний Жанжин штабын цогцолбор шалгалтыг нэгдсэн бодлого, төлөвлөгөөгөөр оролцогч ангиудын удирдлага, штабтай хоёр талын команд штабын сургууль, салбар, нэгжүүдтэй тактикийн хээрийн сургуулийг явуулж бэлэн байдал, бэлтгэлжилтийн түвшинг тогтоосон. Түүнчлэн дайчилгаатай команд штабын хээрийн сургуулийг амжилттай явуулж, тусгай ажиллагааны сургалтыг хөдөлгөөнт бүлгээр өндөр ачаалалтай амжилттай зохион байгуулсныг онцлон тэмдэглэж байна.

Мөн нэгтгэл, анги, салбарын хээрийн гаралт, полигоны дадлага сургуулийг богино хугацаанд чанартай бэлтгэн амжилттай зохион байгуулсны дотор зарим сургалт цахим хэлбэрээр явагдаж бие бүрэлдэхүүний мэргэжлийн ур чадварын түвшин нэмэгдэж, үүрэг гүйцэтгэх чадавхтай тасаг, салаа, салбарыг бэлтгэхэд чухал нөлөө үзүүлээ. Хэдийгээр дэлхий нийтийг цочроосон цар тахлын улмаас улсын хэмжээнд гамшгаас хамгаалах Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжээд байгаа ч хуулиар



хүлээсэн үндсэн болон бусад чиг үүргийг гүйцэтгэхэд Зэвсэгт хүчин ямагт бэлэн байх ёстой. Иймд өмнөө тавигдсан үүргийг биелүүлэхэд цэргийн сургалт бэлтгэлийг тасралтгүй явуулж, өмнөх сургуулийн жилийн ололт амжилтаа бататган, 2020-2021 оны сургуулийн жилд дэвшүүлсэн зорилго, зорилтыг биелүүлж, сургалтад бүх төрлийн дэвшилтэт технологи, арга, хэлбэрийг ашиглан үр дүнтэй зохион байгуулахад бүх шатны албан тушаалтнууд

онцгой анхаарч ажиллахыг даалгаж байна.

Зэвсэгт хүчний 2020-2021 оны сургуулийн жил нь Батлан хамгаалах яамны 110 жил, Зэвсэгт хүчний 100 жилийн ойг угтсан олон арга хэмжээтэй давхцахын зэрэгцээ Зэвсэгт хүчний бүтцэд Төрлийн цэргүүд шинээр бий болсон, улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтад дахь Зэвсэгт хүчний оролцоо өргөжсөн, цэргийн сургалт бэлтгэлийн тогтолцоог шинэчилсэн зэрэг онцлогтой жил байх болно. Мөн энэ сургуулийн жилд Зэвсэгт хүчний ахлагч нарын бүрэлдэхүүний бие бялдрын бэлтгэлжилт, эрүүл мэндийг дээшлүүлэх жил болгон, хэрэгжилтийг нь ханган ажиллаж байгаагаараа бас онцлогтой болж байна.

Та бүхэн мэргэжлийн өндөр чадвартай, шинийг эрэлхийлэгч, мэргэшсэн цэргийн алба хаагч байж, Зэвсэгт хүчний бэлэн байдлыг хангах үндсэн асуудал болсон цэргийн сургалт бэлтгэлдээ өндөр амжилт гаргахыг хүсэн ерөөе!

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН ДАРГА, ХОШУУЧ ГЕНЕРАЛ Д.ГАНЗОРИГ

КОРОНАВИРУСИЙН ХАЛДВАРААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛБЭ!



- ✓ Маскаа зүү
- ✓ Гараа угаа
- ✓ Дархлаагаа дэмж
- ✓ Бусдыг хүндэл
- ✓ Өөрийгөө хамгаал

ЦАХИМ ОРЧНЫ ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭГ БИЙ БОЛГОЦГООЁ

Эдүгээ харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэвшил болсон интернэт, гар утас, цахим шуудан, фэйсбүүк хаягаараа хуваалцаж байгаа (share), дэмжиж эсвэл эсэргүүцэж байгаа (Like or dislike), өөрийн санаа бодлыг илэрхийлж байгаа (comment) мэдээ, мэдээлэл нь тухайн хүний хандлага, ёс зүйг тод томруун харуулах нэг илэрхийлэл болсон. Энэ нь хувь хүний мэдээ,

мэдээллийг мэдэх эрх чөлөө боловч цэргийн алба хаагчийн хувьд өөр асуудал юм. Учир нь Зэвсэгт хүчний үйл ажиллагаа, цэргийн албатай холбогдох мэдээ, мэдээллийг олон нийтийн сүлжээнд тавьснаар албаны нууцлал, аюулгүй байдал, байгууллагын дотоод зохион байгуулалтад нөлөөлөхүйц хүндрэл үүсгэх үндсэн нөхцөл болж байна.

Уг нийтлэлийг бичихээс өмнө цэргийн сэтгүүлч "Дүрэмт хувцастай зураг цахим орчинд байж болдоггүй юм уу?" гэсэн энгийн асуултыг Мэдээллийн аюулгүй байдлын албанд тавьсан. Үүнийг бид мэргэжлийн байр сууринаас өргөн хүрээтэй, цаад мөн чанарыг нь цэргийн алба хаагчдад ойлгуулах талаас нь хариулахыг хичээлээ. Цэрэг хүн Цэргийн тангараг өргөснөөс

хойш цэргийн албаны онцлог, дүрэм, журмаар тогтоосон хэм хэмжээнд захирагдаж, төрийн нууцын тухай хуулийг чанд мөрдөн биелүүлэх ёстой байдгийг та бүхэн сайн мэднэ. Цэргийн алба хаагчийн хэлсэн үг, хийсэн үйлдэл, албаны хувцас, хэрэглэл нь нийгмийн толь болж, олон нийт түүнийг соргогоор хүлээж авдаг учраас цахим сүлжээнд алба, ажилтай холбогдсон

мэдээ, мэдээллийг зөвшөөрөлгүй түгээхийг хязгаарлах, хориглох гээд байгаагийн учир шалтгааныг таниулах, өөрийн болон хамт олон, найз нөхдийн тухай эерэг болон сөрөг мэдээ, мэдээлэл тархахаас хамгаалах, зайлсхийх, таслан зогсоох хүртэлх арга хэмжээг хэрэгжүүлэхийн ач холбогдлыг сонини энэ дугаараар онцолж буй нь энэ.

(Үргэлжлэл нь II нүүрт)

ЦАХИМ ОРЧНЫ ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭГ БИЙ БОЛГОЦГООЁ

(Түрүүч нь I нүүрт)

АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ УЧИР ШАЛТГААНЫГ ОЙЛГОХООС ЭХЭЛНЭ

Сүүлийн жилүүдэд гаднын орнуудын туршлага, сургамжуудыг судлахад цэргийн алба хаагчдын үүрэг гүйцэтгэлтийн, сургалт бэлтгэлжилтийн буруугаас шалтгаалсан алдаа, эндэгдэл гарах нь багасаж, харин интернэт, ухаалаг гар утасны болон байршил тогтоогчийг идэвхжүүлэн олон нийтийн сүлжээний хувийн хаягтаа байршуулснаас ажиллагааны газар орон, хөдөлгөөний маршрутын мэдээлэл алдагдаж, сөрөг үр дагаварт хүргэсэн жишээ цөөнгүй гарчээ. Харин манай цэргийн алба хаагчдын хувьд дүрэмт хувцасны зөрчилтэй зургаа байрлуулах, цэргийн зэвсэг, техникийн онцлогийг харуулсан зураг, дүрс оруулах, цэргийн ажил, амьдралыг нийтэд зөвшөөрөлгүй дэлгэхийг уриалан дуудах,

нөхцөл байдлыг бага ухаарч байгаатай холбоотой.

Монгол Улсын хууль тогтоомж, цэргийн тангараг, дүрэм, журамд төрийн, албаны, хувь хүний нууц, аюулгүй байдалтай холбогдох мэдээ, мэдээллийг хамгаалах, олон нийтийн сүлжээгээр тархаахгүй, задруулахгүй байх, нам, эвсэл, холбооны гишүүн байхыг хориглоод зогсохгүй тэдний үйл ажиллагааг сурталчлахгүй байх заалтууд хангалттай тусгагдсан. Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб албан даалгавар, зөвлөмжийг боловсруулан Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбар, цэргийн алба хаагчдад энэ талын мэдээллийг албаны шугамаар хүргүүлсээр ч ирсэн. Үүнээс үүдэн “Эдгээр албаны баримт бичгүүдээс Та юуг ойлгож, мэдэж авсан байх шаардлагатай бэ?”, “Зэвсэгт хүчнийг олон нийтийн сүлжээгээр хувийн хаягаасаа сурталчлах албан ёсны субъект нь Та мөн үү?”, “Өөрийн тавьсан мэдээ, мэдээлэлдээ баталгаа өгч

холбогдох хэсэг, өөрийгөө болон хамтран ажиллагчдынхаа албаны үйл ажиллагааны онцлог, давуу болон сул талыг харуулсан хээрийн болон албаны хувцастай гэрэл зураг, аудио, видео дүрс, гар утасны болон агаарын тээврийн байршил тогтоогч хэрэгслийн үйлчилгээний

Агуулгыг нарийсгаж хэлбэл, Зэвсэгт хүчний офицер, ахлагч, гэрээт болон хугацаат албаны түрүүч, байлдагч, цэргийн сургуулийн сонсогч нар, тусгай болон энхийг сахиулах үүрэг гүйцэтгэж буй бүрэлдэхүүн, хуулиар цэргийн сургалтад хамрагдаж буй бэлтгэл үүрэгтэн,

гэж ойлгох хэрэгтэй. Тиймээс албан ажлаа хийж явцдаа хувийн компьютер, гар утасны программ, техник, технологийн тохиргоог “идэвхжээгүй” ажлын горимд тавьж сурах нь маш чухал гэдгийг Та байнга санаж, хэвшүүлээрэй.

Энд тодруулж хэлэхэд, цэргийн алба хаагчдыг цахим хувийн хаягтай байхыг хориглоогүй ч Таныг уг хаягтаа албаны дүрэмт хувцас хэрэглэсэн, нүүр хуудасны мэдээлэлдээ гүйцэтгэж байгаа албан тушаал, мэргэжил, хаяг байршил, амьдарч буй хот, засаг захиргааны нэгжийг хамааруулан бүртгэлжүүлэхгүй байхыг зөвлөө.

ЗӨВ ХЭРЭГЛЭЭНД ДАДАХ НЬ ЧУХАЛ

Интернэт, гар утас бол хүн төрөлхтний харилцааны гол хэрэглүүр болохын хувьд ухаалаг, зөв зохистой хэрэглээг бүрдүүлж, ажил, албандаа ашиглах шаардлага бидэнд тавигдаж байна. Гэтэл сүүлийн үед дан залуус ч гэлтгүй бүх насныхан цахим үйлчилгээнд донтох болсон. Үүнээс болж бие бүрэлдэхүүний ажлын бүтээмж, сурч боловсрох цаг хугацаа, биеийн эрүүл мэнд зэрэг олон зүйлд сөргөөр нөлөөлж эхлээд байна. Тиймээс мэдээллийн аюулгүй байдлыг хангах үүднээс төрийн болон албаны нууцыг хамгаалах, горимыг мөрдүүлэх, нөгөө талаас цэргийн алба хаагчдыг цахим орчны зөв хэрэглээнд сургах зорилт зайлшгүй дэвшигдэж байна.

Иймд тухайн анги, байгууллагын удирдлага, хамт олон дээр дурдсан цахим орчны ухаалаг, зөв зохистой хэрэглээг төлөвшүүлэхэд анхаарч, энэ талын мэдлэг, боловсролыг цэргийн алба хаагчдад олгоход бүх талаар анхаарах хэрэгтэй. Ингэхдээ ажлын байрандаа хувийн интернэт, ухаалаг утасны зарим үйлчилгээнээс татгалзах шалтгаан, үндэслэл, ач холбогдлыг онолын үүднээс нь сайтар тайлбарлан таниулж, хий хоосон хэлбэр хөөсөн байдлаар биш, баримтад тулгуурлан харилцан санал солилцох, зөвшилцөх, үзүүлэн таниулах, ойлголцох хэлбэрээр зохион байгуулж хэвших хэрэгтэй байна.

Эцэст нь төрийн хүний хувьд цахим орчинд хариуцлагагүй үйлдэл хийдэггүй ёс зүйтэй байж, хязгаарласан үйлчилгээний горимыг сахиулах, мэдээ, мэдээлэл алдагдахаас сэргийлж, үнэт цаг, боломжоо үр дүнтэй ашиглаж, бүтээлчээр ажиллахыг уриалж байна.

ЗХЖШ-ын Удирдлага, холбоо, мэдээллийн аюулгүй байдлын хэлтсийн дарга, хурандаа М.ЗОЛЗАЯА



5,185 Хүрсэн хүний тоо 535 Engagements **Нийтлэлийг дэмжих**

Та болон өөр 80 хүн 10 сэтгэгдэл 9 удаа хуваалцсан

Таалагдлаа Сэтгэгдэл Хуваалцах



14,523 Хүрсэн хүний тоо 2,422 Engagements **Нийтлэлийг дэмжих**

314 70 сэтгэгдэл 83 удаа хуваалцсан

Таалагдлаа Сэтгэгдэл Хуваалцах

тусламжтайгаар өөрийнхөө хаана байрлаж, хаашаа хөдөлгөөн үйлдэж байгаа чиглэл зэргийг илэрхийлэх хувийн болон албаны нууцлал, аюулгүй байдалтай шууд холбоотой гэдгийг ойлгоорой.

Ер нь гадаадын болон өөрийн орны гаднын харьяат иргэдтэй харилцахгүй байх, хувийн шугамаар найзлах хүсэлт илгээх, өөрийн болон гэр бүлийн гишүүдийнхээ цахим банкны данс, ажил, сургуулийн нэр, хаяг, байршлын тухай мэдээллийг цэргийн алба хаагч хувийн хаягтаа байлгах шаардлагагүй. Эдгээрийн учир шалтгааныг Та цэргийн алба хаагчийнхаа хувьд мэдэж, мэдээ, мэдээлэлтэй холбогдох эрсдэлд орохоос өөрийгөө хамгаалж, цахим орчны ухаалаг, зөв хэрэглээг бүрдүүлэх, төлөвшүүлэх нь чухал юм.

ЦАХИМ ОРЧНЫ ХЭРЭГЛЭЭНИЙ ХАМРАХ ХҮРЭЭГ ТОГТООЖ, ХЯЗГААРЛАЛТ ХИЙХ НЬ ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ НӨХЦӨЛ МӨН

Цэргийн нэгтгэл, ангийн байрлал, дадлага, сургуулийн талбай дээр тодорхой нөхцөлтэйгөөр цахим орчны хэрэглээний хамрах хүрээг тогтоож, хязгаарлалт хийх нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндсэн арга хэмжээ юм.

оюутан цэрэг, цэргийн анги, байгууллагад энгийнээр ажиллаж байгаа ажилтан албан хаагч, гэрээгээр түр үүрэг гүйцэтгэж байгаа иргэд, цэргийн ангид албан ажлаар түр нэвтрэх зөвшөөрөл олгогдсон иргэд, олон улсын хамтарсан команд штабын сургууль, хээрийн сургуульд оролцож байгаа офицер, ахлагч нарт цахим орчны үйлчилгээг тогтоосон горимоор ашиглах боломжийг нээн өгч байгаа хэрэг юм.

Өөрөөр хэлбэл, ажил, арга хэмжээний нууцлал, аюулгүй байдалд хяналт тавихын тулд байршил тогтоогч идэвхжүүлэх, утасгүй сүлжээнд холболт хийх, фото болон видео бичлэг хийх, интернэт болон дотоод сүлжээнд холбох, интернэт, гар утаснаас мэдээлэл тараах, хадгалах, зөөх хэрэгсэл ашиглах, хувийн хэрэгцээний гар станц, радио нэвтрүүлэгчийг нэвтрүүлэг дээр ажиллуулах, зөөврийн бүх мэдээлэл тээгчийг албаны компьютерт холбох зэрэг сүлжээний үйлчилгээг зарчмын хувьд хязгаарлалттай горимоор хэрэглэж, хориглоно гэсэн үг. Иймд цэргийн байгууллага дээр ашиглахыг зөвшөөрсөн интернэт болон ухаалаг гар утасны үйлчилгээг урвуулан хувийн хэрэгцээндээ ашигладаггүй, тогтоосон хязгаарлалтыг дагаж мөрддөг ёс зүйтэй байх нь цэргийн алба хаагчийн үүрэг

гадаад улс орон руу зорчих үедээ сүлжээнд нислэгийн маршрутаа байршуулах, өөрийн гэр бүлийн гишүүд, балчир хүүхдийн болон тэтгэвэр, чөлөөнд гараад хийж гүйцэтгэж байсан алба, үүргийг бусдад дурсамж болгон дэлгэх, ой, тэмдэглэлт өдрүүдээр сүлжээнд дүрэмт хувцастай зураг, бичлэг тавьж, талархал мэндчилгээ дэвшүүлэн олноороо идэвхжин давлагаалах зэрэг эерэг, сөрөг үр дагавартай мэдээ, мэдээлэл түгээх үзэгдэл элбэг болсон. Таны хувьд хувийн гэсэн мэдээлэл дотор албан хэрэгцээнд хамаарах мэдээ, мэдээлэл хавсрагдсан байна гэдгийг мэдэхгүйгээр олон нийтэд түгээх нь цэргийн байгууллагын онцлогийг үл анзаарч, үүсэж болох уршигт

чадах итгэл үнэмшил Танд байна уу?” гэсэн асуултад урган гарч ирнэ.

Иймд цэргийн анги, байгууллагын дугаар, бүрэлдэхүүн, байр, байдал, боломжтой холбоотой мэдээллүүд, тусгай зориулалтын болон байлдааны техник хэрэгслийн зураг, дүрс, бүдүүвч, ажиллах заавар, анги, байгууллагын байнгын байрлал, энхийг сахиулах үүрэг гүйцэтгэж байгаа газар орон, сургуулийн талбай, тусгай томилгоот бие бүрэлдэхүүний гүйцэтгэх үүрэг, ажиллагааны зорилго, зорилт, зам, маршрут, хөдөлгөөн байрлал, нэгдсэн төлөвлөгөөгөөр зохион байгуулсан болон хойшлуулшгүй үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийн

“ЭХ ОРНЫ ХҮҮ” БОЛЛОО



Зэвсэгт хүчний 013 дугаар ангид 2020 оны хоёрдугаар ээлжээр хугацаат цэргийн албанд татагдсан дайчид цэргийн анхан шатны бэлтгэл сургалтыг амжилттай дуусгаж, Цэргийн тангаргаа өргөлөө.

Энэхүү ёслолын ажиллагаанд ангийн захирагч, хурандаа С.Пүрэвдорж болон захирагчийн зөвлөлийн гишүүд оролцож, тангараг өргөсөн дайчдад баяр хүргэн цаашдынх нь цэргийн албанд өндөр амжилтыг хүслээ. Мөн цэргийн анхан шатны бэлтгэл сургалтын үед зохион байгуулсан уралдаан, тэмцээнд амжилттай оролцсон хугацаат цэргийн алба хаагчдад шагнал гардуулав.

Мөн Цэргийн тангараг өргөсөн дайчдыг ар гэртэй нь цахимаар холбож, цэрэг эрсийн талархлыг аав, ээжид нь дамжууллаа. Түүнчлэн ангийн Эрүүл мэндийн төвөөс хугацаат цэргийн алба хаагчдад өдөрт хоёр удаа үзлэг хийн, ариутгал халдваргүйтгэлийг тогтмол хийж байна.

Хошууч С.БАТБААТАР

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛ ...

Коронавирусын халдвар, тархалтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан алба, салбар бүрд зөвлөмж, зөвлөгөөг хүргүүлсэн. Энэхүү ажлын хүрээнд Зэвсэгт хүчний 331 дүгээр ангийн албан тушаалын орон сууцанд амьдарч байгаа 0-8 настай хүүхэдтэй айл өрх бүрд зөвлөмжийг хүргүүлэн орчны цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтэд хяналт тавин ажиллаж байна. Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалын албан даалгаврын дагуу бүлгүүдэд тодотгол хийж цацлага, гар ариутгагч, цагаан бээлий, амны хаалтыг байнга хэрэглэж хэвшихийг уриалга болгоод байна.




Мөн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор нийт бие бүрэлдэхүүнтэй сургалт, дадлагыг зохион байгуулав.

Ахмад Д.БААСАНЖАВ

СУРГУУЛИЙН ЖИЛИЙН НЭЭЛТҮҮД ЦАХИМААР ЯВАГДАВ

Зэвсэгт хүчний 2020-2021 оны сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу сургуулийн жилийн нээлттэй Зэвсэгт хүчний Жанжин штабын бүрэлдэхүүн цахимаар зохион байгууллаа. Нээлтийн ажиллагааны үеэр Зэвсэгт хүчний Жанжин штабын орлогч дарга, хошууч генерал Ж.Бадамбазар ЗХЖШ-ын газар, хэлтсийн дарга нарт хандаж “Зэвсэгт хүчний 2020-2021 оны сургуулийн жилийн онцлог нь Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний түүхэн ой тохиож буйгаар тодорхойлогдоно. Тэрчлэн дэлхий нийтийг хамарсан “Ковид-19” цар тахал манай улсад гарч Бүх нийтийн бэлэн байдлын зэргийн үед зохион байгуулагдаж байгаагаараа онцлог болж байна” гээд шинэ сургуулийн жилийн бусад онцлог, цаашид анхаарах асуудлуудын талаар



үүрэг, чиглэл өглөө.

Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлал, нэгтгэл, ангиудын шинэ сургуулийн жилийн нээлт цахимаар боллоо. Хуурай замын цэргийн командлагч, бригадын генерал Б.Амгаланбаатар сургуулийн жилийн нээлтэд хэлсэн үгэндээ “Хуурай замын цэргийн командлалаас “Хуурай замын цэргийн үндсэн болон хуулиар хүлээсэн үүрэг гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлэхэд цэргийн сургалт бэлтгэлийг чиглүүлэн нэгтгэл, анги, салбаруудын удирдлага, штабын бэлтгэлийг төгөлдөржүүлж, бэлэн байдлыг дээшлүүлэх” зорилгыг 2020-2021

оны сургуулийн жилийн үндсэн зорилго болгон ажиллаж байна. Энэхүү зорилгын хүрээнд Хуурай замын цэргийн нэгтгэл, ангиудын сургалт бэлтгэлийн төлөвлөлт, удирдлага, зохион байгуулалтын уялдаа, холбоог хангах, штабын бэлтгэл сургалтын чанар, бие бүрэлдэхүүний мэдлэг, дадлага, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, үүрэг гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлэх зэрэг ажлыг нэгтгэл, ангиудын онцлогтой уялдуулан зохион байгуулна” гээд бие бүрэлдэхүүнд сургалт бэлтгэл, сахилга, хариуцлагын талаар үүрэг, чиглэл өгч, шинэ сургуулийн жилдээ тавьсан зорилго, зорилго бүрэн хангаж ажиллахыг уриалсан юм.

ЗЭВСЭГТ ХҮЧИН-100 ЖИЛ

ТУСТАЙ САЛБАРЫНХНЫ ТУЧУХ АРВИН ...

Тэртээ 49 жилийн өмнө Өмнөговь аймгийн төвд байгуулагдсан анхны цэргийн анги болж, тус өдрийнхөө 17.35 цагт түлхүүр цохиж төвтэй холбоонд орсноос хойш хагас зуун жилийг түүчээлж байгаа Цэргийн гавьяаны одонт Зэвсэгт хүчний 124 дүгээр ангийн 148 дугаар тусгай ротын захирагч, хошууч Б.АЛТАНГЭРЭЛТЭЙ холбогдож тус салбарын онцлог, ажил үйлс, хийж бүтээсэн болон хийхээр зэхэж буй бүтээлч ажлуудын талаар ярилцсанаа хүргэж байна.



Зэвсгийн өрөө, зэвсгийн агуулахыг "Цэргийн албыг зохион байгуулах заавар"-ын дагуу тохижуулж, шуурхай ажиллагааг нь ханган ажиллаж байна. Мөн байнгын жижүүрлэлт, үйл ажиллагааг сайжруулах зорилгоор удирдлагын байрыг зохион байгуулалтад оруулж, ажлын байрыг засварласан. ЗХЖШ-ын Удирдлага, холбоо, мэдээллийн аюулгүй байдлын хэлтсийн дэмжлэгтэйгээр

эерөө, зэвсгийн агуулахыг "Цэргийн албыг зохион байгуулах заавар"-ын дагуу тохижуулж, шуурхай ажиллагааг нь ханган ажиллаж байна. Мөн байнгын жижүүрлэлт, үйл ажиллагааг сайжруулах зорилгоор удирдлагын байрыг зохион байгуулалтад оруулж, ажлын байрыг засварласан. ЗХЖШ-ын Удирдлага, холбоо, мэдээллийн аюулгүй байдлын хэлтсийн дэмжлэгтэйгээр

эерөө, зэвсгийн агуулахыг "Цэргийн албыг зохион байгуулах заавар"-ын дагуу тохижуулж, шуурхай ажиллагааг нь ханган ажиллаж байна. Мөн байнгын жижүүрлэлт, үйл ажиллагааг сайжруулах зорилгоор удирдлагын байрыг зохион байгуулалтад оруулж, ажлын байрыг засварласан. ЗХЖШ-ын Удирдлага, холбоо, мэдээллийн аюулгүй байдлын хэлтсийн дэмжлэгтэйгээр

Танай салбарын үндсэн үүрэг, үйл ажиллагааны онцлогийн талаар яриагаа эхэлье ...

-Тусгай рот нь жижүүрлэлтийн ажиллагааг өдөр, шөнийн 24 цагийн хугацаанд тасралтгүй зохион байгуулдаг. Тус салбарт ажиллаж байгаа алба хаагчид нь мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэгдсэн, ажлын дадлага, туршлага, ур чадвартай, ажлын байрны шаардлагадаа нийцүүлэн ажилладаг, хурд ихтэй, хос морьтой, төрийн нүд, чих болсон холбоочин офицер, ахлагч нар байдгаараа онцлогтой.

Сүүлийн үед хэрэгжүүлж байгаа ажлаасаа дурдвал ...

-Бид бэлэн байдал, сургалт бэлтгэлээ сайжруулах талаар олон ажлыг төлөвлөн хэрэгжүүлж байна. Эдгээрээс төв ангийн хэмжээнд үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэх техникийн ололт хөгжлийг судлах, нэвтрүүлэх зорилгоор явагдаж буй "Шилдэг бүтээл, шинэ санаа" аяны хүрээнд манай салбар нь хээрийн хөдөлгөөнт радио техникийн эрэл хайгуулын бүлгийн нэгж автомашиныг

-2020-2021 оны сургуулийн жилийн зорилгын хүрээнд тусгай рот нь "Удирдлагыг ангийн гүйцэтгэх үүрэг, хуулиар хүлээсэн бусад үүргийг гүйцэтгэх ажиллагаанд жигдрүүлж, үндсэн болон томилгоот бүлгүүдийн үүрэг гүйцэтгэх чадавх, зэвсэглэл, техникийн бэлэн байдлыг ханган, тайван цагийн орон тоогоор үүрэг гүйцэтгэх бэлтгэлжилтийг дээшлүүлэх" зорилгыг дэвшүүлэн цэргийн сургалт бэлтгэлийг зохион байгуулж байна.

Хорио цээрийн дэглэмтэй энэ үед сургалтыг хэрхэн зохион байгуулж байна вэ?

-ЗХЖШ-ын даргын удирдамжийн дагуу сургалтыг цахимаар явуулж хэвшээд байна. Байнгынжижүүрлэлтийн үүрэг гүйцэтгэдэг нэгжийн хувьд цахим, зайны сургалтад дараах давуу талууд ажиглагдаж байна. Тухайлбал, шалтгаантай албан хаагчид хаанаас ч хамрагдах боломжтой, бие бүрэлдэхүүний хичээлийн ирц, хамрагдалт хангалттай буюу 90-ээс дээш хувь, хичээлийг хугацаанд нь давтан судлах боломж бүрдээд байна. Мөн

байна. Түүнчлэн ЗХЖШ-аас мэргэжлийн суурь хичээлийн хөтөлбөрийг 2020-2021 оны сургуулийн жилд нэгдсэн журмаар баталж өгсөн нь сургалтыг зохион байгуулах явцад юуг судлах, хаана хүрэх зэрэг нэгдсэн ойлголтод хүрч үр дүн, ач холбогдол нь тодорхой болсон.

Тус ротын ой тохиоход жил хүрэхгүй хугацаа үлдсэн байна. Ойдоо барих амжилт бүтээл, хийж хэрэгжүүлж буй ажлынхаа талаар ...

-Тусгай салбарын түүхт 50 жилийн ой ирэх онд болно. Бид ойгоо угтаж нэн тэргүүнд тус ротод сэтгэл зүрх, хүч хөдөлмөр, залуу насаа зориулан ажиллаж байсан үе үеийн ахмадуудынхаа алдар гавьяа, ажлын сургамж, дайчин замналыг тодотгох ажлыг эхлүүлээд байна. Түүнчлэн бүтээлч ажлын хүрээнд тусгай ротын хотхонд

Зэвсэгт хүчний дотоод сүлжээний өндөр хурдны шилэн кабельд холбох ажлыг өөрсдийн хүч хэрэгслээр амжилттай гүйцэтгэсэн. Өндөр хурдны шилэн кабелийн сүлжээг ашиглан Зэвсэгт хүчний дотоод сүлжээнд холбогдон холбоочдын тусгай тактикийн хээрийн сургуулиалтын үед удирдлагын байруудтай алсын зайнаас онлайн видео хэлбэрээр холбогдсон нь Зэвсэгт хүчний тусгай салбаруудаас анхных болсноороо онцлогтой юм.

Мөн хичээлийн танхимыг өргөтгөн бүрэн засвар хийхийн зэрэгцээ ангийн жагсаалын талбайг 200 м² тэлж өргөтгөн, хотхоны гэрэлтүүлгийн 20 ширхэг багана, гадна 38 ширхэг гэрэлтүүлгийн шинээр суурилуулан угсарсан. Түүнчлэн байнгын жижүүрлэлтийн үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн алба хаагчдыг амт чанартай хоолоор хангах зорилгоор төмс, лууван, манжин, сонгино, тарвас, өргөст хэмх зэргийг хүлэмж, талбайд тариалан хүнсний хэрэгцээнд хэрэглэж байна. Зарим алба хаагчдын санаачилгаар шалган нэвтрүүлэх байрыг шинээр барьж, хотхоны хашааг 90 метр тэллээ. Ахмадуудтайгаа хамтраад тусгай ротын хашаанд 500 ширхэг чацаргана, 200 ширхэг алимны мод, 260 м² зүлэг тарьж ургуулсан. Шалган нэвтрүүлэх байрыг ухаалаг цахим хэлбэрт шилжүүлэн "домифон" системийг суурилуулж шуурхай жижүүрээс удирдах боломжийг нь хангаж, автомашин орох хэсгийн 12 метр авто замыг бетоноор цутгаж, мөн 12 метр явган замын гэрэлтүүлэг хийсэн зэрэг олон ажлыг ойн хүрээнд санаачлан хэрэгжүүлээ.

Шалган нэвтрүүлэх байрыг цахим болгосны онцлог, давуу тал нь юу байв?

-Техник, технологийн ололт, дэвшил, цаг хугацаатай уралдан бидний нүдэн дээр хөгжиж, хувьсан өөрчлөгдөж байна. Тиймээс бид энэхүү хөгжилтэй хөлнийлүүлэн алхах үүднээс шалган нэвтрүүлэх байрын явган зорчих хаалгаа цахим болгосон юм. Энэ "4 мега Pixel" нягтралтай дуран бүхий төхөөрөмж нь нэвтрэх үнэмлэхийг таньдаг учраас хаалга автоматаар нээгддэг болж байгаа юм. Ингэснээр албаны нэвтрэх үнэмлэх нь үзлэгт шалгуулдаг бус өдөр тутмын зайлшгүй хэрэглээ болж хэвшсэн. Энэ нь цар тахлын үед шалган нэвтрүүлэх байрын жижүүр, туслагч нарын зүгээс нэвтрэгсэдтэй ойр зайнаас харьцахгүй байх эрүүл ахуйн болон бусад чиглэлээр өндөр үр дүнтэй юм.

Мөн ахлах ахлагч Б.Батбаяр санаачлан "Цэргийн албыг зохион байгуулах заавар"-ын дагуу авто машин, техникийг нэвтрүүлэх хаалганы зураг, төслийг гаргаснаар шинээр тохижуулсны зэрэгцээ алсын удирдлага бүхий моторыг төхөөрөмжлөн угсарч бүрэн автомат байдалд шилжүүлсэн. Дээрх ажлуудыг ангийн хамт

Орон нутгийн байгууллагуудтай хэрхэн хамтран ажиллаж байна вэ?

-Тусгай рот нь аймаг, орон нутгийнхаа удирдлага, Цэргийн штаб, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудтай нягт уялдаа холбоотой ажиллаж ирсэн уламжлалтай. Түүнчлэн төрийн үйлчилгээг офицер, ахлагч, ажилтан алба хаагчдад хүргэх, Батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах, сайн үйлсийн аянд нэгдэх, соёл хүмүүжил, спортын арга хэмжээнд оролцох зэргээр хамтран ажиллаж байна.

Мөн энэ оны 3 дугаар сард аймгийн Засаг дарга Н.Наранбаатар болон орон нутгийн удирдлагууд тус салбарын үйл ажиллагаатай биечлэн танилцаж тулгамдаж буй зарим асуудлыг шийдвэрлэж өгсөн. Тухайлбал, тусгай ротын ажлын байрны 40 хувьд нь халаалт, дулааны шугамтай байсныг 100 хувь бүрэн шинэчилсэн, нэг цэргийн алба хаагчид орон сууц худалдан авахад мөнгөн тусламж үзүүлж хуучин уурын зуух байсан байрыг засварлан буудал болгож тохижуулсан. Мөн агуулахын дээврийг шинэчилж, суудлын шинэ автомашин өгсөн явдал нь ангийн бие бүрэлдэхүүний ажиллах, амьдрах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн бодит дэмжлэг болсон юм.

Цаашид хийхээр төлөвлөж байгаа ажлынхаа талаар сонирхуулахгүй юу?

-Үндсэн үүргээ гүйцэтгэх боломжийг дээшлүүлэх, бие бүрэлдэхүүнтэй дадлага давамгайлсан цэргийн сургалтыг зохион байгуулж үр дүнг дээшлүүлэх, ажиллагааны хяналтын цахим планшет дэлгэцийг бүтээх ажлыг судалж хэрэгжүүлэх, үндсэн үйл ажиллагаа, штабын дадлага сургалтад нэвтрүүлэх, ажиллагааны сан хөмрөг, мэдээлэл боловсруулалтын цахим санг байгуулж, нууцлалыг хангах, автотехникийн бэлэн байдлыг хангах засвар, үйлчилгээний талбайг байгуулан тохижуулах, биеийн тамирын гадна талбайг өргөтгөх, шаардагдах хэрэгслүүдээр тоноглож тохижуулах зэрэг төлөвлөсөн ажил их бий. Мөн говийн онцгой нөхцөлд томилгоот бүлгийн үүрэг гүйцэтгэх боломжийг дээшлүүлэх ч ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх болно.

Хошууч Д.ОЮУНГЭРЭЛ



Холбоочдын тусгай тактикийн хээрийн сургуулийн үеэр



Хээрийн байрлал холбоонд орж байгаа нь

тоноглох, үүрэг гүйцэтгэх боломжийг нь дээшлүүлэх чиглэлээр санаачилга гарган ажиллаж байна.

Цэргийн сургалт бэлтгэлийн талаар ...

офицер, ахлагч, ажилтан алба хаагчдын компьютер, мэдээллийн хэрэгсэл, программ хангамжийг ашиглах, суралцах, хөгжмийг мэдлэг, ур чадвар дээшилж

зарлан мэдээллийн дуут систем, хяналтын "IP" иж бүрэн камер, ажлын байранд дотуур холбооны тоон телефон станцыг суурилуулан төхөөрөмжиллөө. Шинээр

ЗЭВСЭГТ ХҮЧИН-100 ЖИЛ

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙГ БЭХЖҮҮЛСЭН ОН ЖИЛҮҮД

**БХЭШХ-ийн
Д.Гомбосүрэнгийн нэрэмжит
Цэргийн түүх судлалын
төвийн дарга, доктор (Ph.D),
хошууч Т.СҮХБААТАР**

Монголын ард түмэн 1921 оны хувьсгалаар эх орноо харийн түрэмгийлэгчдээс чөлөөлж, төр, түмнээ төвшитгөн тохионуулах ажлыг бүхий л салбарт эрчимтэй хэрэгжүүлсний нэг нь Зэвсэгт хүчин байсан юм.

Ялангуяа Ардын журамт цэргийг байнгын арми болгон хөгжүүлэн бэхжүүлэх эхний арваад жил бол манай шинэ үеийн Зэвсэгт хүчний хөгжлийн оршихуй, эс оршихуйн хамгийн хүнд сорилтын цаг хугацаа, он жилүүд байсан юм.

Юуны өмнө Зэвсэгт хүчний хөгжилд улс орны болон ард түмний хөгжлийн хоцрогдол нөлөөлж байжээ. Европын загвараар цэргийн анги, салбарыг байгуулж, тэднийг зэвсэглэн сургахад хамгийн хүндрэлтэй байсан бэрхшээл нь улс орны эдийн засаг, цэргийн асуудлаарх үндэсний зан үйл байжээ. Хэзээнээс нааш монголчууд цэргийн боловсролыг уламжлалт зан үйлийн өв уламжлал дээр тулгуурлан сурсан бөгөөд аливаа дайн, байлдааны үед нэгдэн нийлэн ирж нэгэн цул цэрэг болдог. Мөн дайн, байлдаан дууссанаас хойш орон нутаг, гэр рүүгээ буцах нь жам ёсны эрх гэж ойлгодог байсан нь байнгын цэрэг, армийг бий болгоход ихээхэн саад болсон юм.

Зэвсэгт хүчний цаашдын хөгжил, бэхжилтэд “МАХН-ын IV Их хурал, БНМАУ-ын II Их хурал (1925) чухал суурь эзэлнэ. Намын IV Их хурлаас баталсан МАХН-ын хоёр дахь программд энэ үеийн цэргийн байгуулалтын зорилт нь “Ардын хувьсгалт улаан цэргийг байгуулах явдалд тус намаас идэвхийлэн оролцож ардын эрх чөлөөг үнэхээр хамгаалж чадах болохын тулд хүчнийг нь зузаатгах...” гэж заажээ. Программд “Хувьсгалт улаан цэргийн тухай” бүлгийг тусгайлан оруулж, түүнд Зэвсэгт хүчнийг байгуулахад эн тэргүүнд цэргийн албан хаагчид, нийт хөдөлмөрчин ардыг цэргийн эрдэмд боловсруулах, байлдааны шинэ зэвсэг, техник, боловсон хүчнээр армийг хангах,

нь цэргийн сургууль байлаа. Их жанжин Д.Сүхбаатарын удирдлага, санаачилгаар Их даргын сургууль (Цэргийн ерөнхий сургууль)-ийг 1921 оны намар байгуулжээ. Богдын Засгийн газрын шийдвэрээр 1912 онд Хаант Оросын туслалцаатайгаар Хужирбуланд байгуулсан сургуулийн суурин дээр уг сургуулийг байгуулсан юм. Тус сургуулийн анхны дамжааг 90 орчим хүнтэй, 6 сарын сургалтын хөтөлбөртэйгөөр зохион байгуулж 1921 оны 8 дугаар сараас 12 дугаар сарын 25-ны өдөр хичээллэж төгссөн байна. Эхний төгсөлтөөр морьт цэргийн салааны дарга 5, туслах дарга 8, хагас салааны дарга 7, бүгд 20 хүн төгсөв. Энэ бол орчин цагийн Зэвсэгт хүчний түүхэн дэх анхны мэргэжлийн боловсон хүчин байжээ.


Зэвсэгт хүчний боловсон хүчнийг зөвхөн дотооддоо бэлтгээд зогсохгүй, 1926 оноос эхлэн ЗХУ-ын Цэргийн дунд сургуулиар, 1930-аад оноос цэргийн академид явуулан сургах болжээ. Ийнхүү 1920-оод оны эцэс, 1930-аад оны эхнээс дотоод, гадаадын цэргийн сургууль төгссөн анхны боловсон хүчнийг Зэвсэгт хүчин хүлээн авах болсон байна. Монгол цэргийн дарга нар анх удаа 1923 онд Улаан армийн цэргийн академи (Одоогийн М.В.Фрунзийн нэрэмжит Ерөнхий цэргийн академи), 1924 оноос В.И.Лениний нэрэмжит Цэрэг-улс төрийн академийн бэлтгэлд нэг жил суралцдаг байснаа Тверь хотын Морьт цэргийн дунд сургуульд 3 жилийн хугацаатай суралцах болов. Бас 1928 оноос нисэхийн сургуульд явуулжээ. ЗХУ-д 1923-1932 онд 139 хүнийг сургахаар явуулснаас 100 орчим нь төгссөн байна. Ийнхүү 1932-1939 онд МАХЦ-т дотоодын дунд сургуулиар 933, гадаадын дээд, дунд сургуулиар 444, нийт 1377 хүнийг бэлтгэн гаргажээ. Төгсөгчдийн 48.4

баян, хүчирхэг бус харин сул дорой эдийн засагтай улс орныг хүлээн авсан юм. Улсын сан хөмрөг үндсэндээ хоосон шахуу байжээ. Аж үйлдвэржээгүй, хөдөө аж ахуйн хоцрогдсон салбартай улс оронд Зэвсэгт хүчиндээ илүүчлэх санхүү, хөрөнгө ч байгаагүй юм. Гагцхүү гаднын зээл, тусламжид найдахаас

газарт олгосон явдал юм.

Өгүүлэн буй үеийн Зэвсэгт хүчний хөгжилд саад тээг болсон нэг зүйл бол улс төрийн их хэлмэгдүүлэлт юм. Улс төрийн хэлмэгдүүлэлт нь улс орны бүхий л түвшинд явагдсанаас Зэвсэгт хүчин хамгийн их өртсөн юм. 1937 онд эхэлсэн улс төрийн хэлмэгдүүлэлтийн уршгаар

болон Хязгаарын ба Дотоодын цэргийн алба хаагч, энгийн хүмүүсээс 1239 хүн, түүний дотор өнөөгийн генерал цолтой дүйцэх цол хүртсэн 78 дээд даргын 66 нь буюу 84.6 хувь нь хэлмэгдэж, ихэнх нь цаазлуулжээ. Судлаач хэлмэгдүүлэлтээр учирсан хор уршгийг “Хувьсгалт хууль ёсыг ноцтойгоор зөрчсөн



өөр арга байсангүй. Өмнө нь ч Хаант Оросоос зээлээр зэвсэг, хэрэгсэл авч байсан түүхтэй. ЗХУ-ын Засгийн газраас 1924 оны эцсээр БНМАУ-д нэг сая рублийн зээллэгийг жилд 4 хувийн хүүтэйгээр таван жилийн хугацаатайгаар олгосон байна. Энэхүү зээллэгээс МАХЦ-ийн хэрэгцээнд зориулан 500 мянган рублийн зэвсгийг гурван жилийн турш (1925-1927 онд)-д олгохоор тохиролцжээ. Энэ бол ЗХУ-аас Монголын Зэвсэгт хүчний чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн анхны томоохон зээллэг байв. Монголын эдийн засгийн хүчин чадал нь тухайн үед шаардагдаж байсан батлан хамгаалах зардлыг бие даан хангах бололцоогүй байсан юм. Иймээс улсын төсвийн

даргалах бүрэлдэхүүн 1938 онд 16.2 хувь, 1939 онд 10.6 хувиар дутагдах болжээ. Зөвхөн 1937 оны 9 дүгээр сараас 1940 оныг хүртэл МАХЦ-ийн даргалах бүрэлдэхүүнээс 500 орчим хүнийг баривчилсан бөгөөд бас 1944 он хүртэл эхлээд бэлтгэлээр, дараа нь улс төрийн найдваргүй этгээд хэмээх хаяг зүүлгэн 1500 орчим дарга нарыг цэргийн албанаас халж, тэдний нэлээд хэсгийг нь баривчлан шийтгэжээ. Зэвсэгт хүчний хэмжээгээр баривчлагдсан цэргийн алба хаагчдын 67.4 хувь нь МАХЦ-т ногдож байгаа нь хэлмэгдүүлэлтийн гол чиглэл, цар хүрээ чухам л армийг дайрсныг нь гэрчилнэ. Энэхүү хоморголон баривчлах ажиллагаа, хэлмэгдүүлэлт,

энэ балмад явдлын уршгаар БНМАУ-ын батлан хамгаалах хүч чадал ноцтой суларч, цэргийн боловсон хүчинд хүнд цохилт болсон. Асар их үнээр бэлтгэсэн цэргийн боловсон хүчин үй олноор хохирсноор юуны өмнө цэргийн боловсон хүчин, цаашилбал үндэсний сэхээтэн бүрэлдэх процесст муугаар нөлөөлжээ” хэмээн дүгнэсэн байдаг.

Зөвлөлтийн Улаан армид 1936-1937 онд нийт офицерын 6.9 хувь, 1938-1939 онд 2.3 хувь нь цэргийн албанаас зайлуулагдсан юм. Үүнтэй харьцуулахад, Монголын Зэвсэгт хүчинд учирсан хохирол Зөвлөлтийн Улаан армийнхаас олон дахин илүү байна. Ийм их хохирол үзсэн арми Сталины дарангуйллын үед Монголоос өөр хаана ч байгаагүй биз ээ.

Энэ мэтээр олон саад бэрхшээл байсан ч 1921-1939 оныг хүртэлх энэ жилүүдэд Монголын цэргийг байнгын армийн хэмжээнд хүргэж, түүнийг үндэсний боловсон хүчин, орчин цагийн байлдааны зэвсэг, техникээр хангах зорилтыг үндсэнд нь шийдвэрлэсэн бөгөөд эх орноо батлан хамгаалах ариун үүргээ нэр төртэй үнэнчээр биелүүлсээр л байсан юм.

Бүгд Найрмдах Монгол Ард Улс 1930-аад оны хоёрдугаар хагасаас цэргийн зардлаа үлэмж нэмэгдүүлсэн нь монголын нийгэм-эдийн засгийн амьдралд эерэг, сөрөг нөлөө үзүүлсэн юм. Эерэг тал нь улс орны батлан хамгаалах чадварыг нэмэгдүүлж, дайсны довтолгоо тогтоон барьж, сөрөг цохилт хийж чадахуйц орчин цагийн армийг байгуулсанд оршино. Сөрөг тал нь улс орны эдийн засгийн тухайн үеийн чадавх, бололцооноос цэргийн зардал үлэмж давж, улмаар ард түмний аж байдал, соёлын хэрэгцээний хөгжилд муугаар нөлөөлж байснаар тайлбарлагдана. Мөн тухайн цаг үеийн хамгийн шилдэг сайн боловсон хүчнээ улс төрийн хэлмэгдүүлэлтэд өртүүлснээр Халхын голын дайны өмнө Зэвсэгт хүчний бэлэн байдал, байлдах чадвар, цэрэг дайчдын эх орон, төр, ард түмэндээ итгэх итгэлийг нь сулруулсан үйл явдал болжээ. Зэвсэгт хүчин байх, эсэх түүнийг гаднын цэргээр орлуулж болзошгүй тийм түүхэн хүнд хэцүү сорилтыг даван туулсан юм.

Орчин цагийн Зэвсэгт хүчин маань 1921 оноос хойш учирч байгаагүй хамгийн томоохон сорилттой тулгарч түүнийг нэр төртэй биелүүлсэн юм. Тэр бол Халхын гол дахь зарлаагүй дайн байлаа.



Жанжин туг ба хороо, ангиудын тугийг их буу, хуягт тэрэг, пулемёт буу зэргийн хамт наадмын тайлбайд байрлуулсан байдал. 1926 он

дайчдын байлдааны болон улс төрийн бэлтгэл, цэргийн сахилгыг бэхжүүлэх нь шинэ армийг байгуулах үндэс гэж үзсэн байна.

БНМАУ-ын II их хурлаас цэрэг байгуулах арга замыг тодорхойлсон. Үүнд, МАХЦ-т залуучуудыг дайчлан татах замаар 5 жилийн дотор (1926-1930) цэргийг байгуулж дуусгах, хязгаарын цэргийн зардлыг улсын төсвөөр хангах, байнгын цэргийг цөөтгөх, нутгийн цэргийн ангиудад залуучуудыг цэргийн бэлтгэлтэй болгох, техникийн цэргийг шинээр байгуулахад гол анхаарлаа чиглүүлэв. Энэ бол улс орны тухайн гадаад, дотоод нөхцөл, эдийн засаг, хүн хүчний нөөцөд тохирсон зөв шийдвэр байсан юм. Юуны юуны өмнө Засгийн газраас цэрэг бэлтгэдэг цоо шинэ хэлбэрийг нэвтрүүлэхээр болсон юм. Энэ

хувь нь төрлийн цэргийн, 26.8 хувь нь командын, 17.1 хувь нь ар тал, эмнэлгийн мэргэжлийн дарга нар байлаа. Үүнээс үзэхэд, танк, холбоо, их буу, нисэх, химийн төрлийн цэргийн боловсон хүчнийг бэлтгэхэд ихээхэн анхаарсныг харуулж байна. Энэ нь БНМАУ-ын Зэвсэгт хүчний бүтцэд чанарын өөрчлөлт гарч, уламжлалт морьт цэргийн зэрэгцээ нисэх хүчин болон төрөл мэргэжлийн цэрэгтэй болсонтой холбоотой байжээ. Ийнхүү 1930-аад оны хоёрдугаар хагас болоход дотоод, гадаадын цэргийн сургуулиар боловсон хүчнийг бэлтгэж МАХЦ-ийн анги, салбарыг үндсэнд нь хангаж чаджээ.

Зэвсэгт хүчний хөгжил, түүний бэхжилтэд хамгийн их нөлөө үзүүлэх зүйл бол эдийн засаг юм. Шинэ Монгол Улс, түүний Засгийн газар

цэргийн зардлын нэлээд хэсгийг ЗХУ-аас бие мөнгөөр буюу байлдааны зэвсэг, техник, зэвсэглэлийг худалдан авахад зориулсан зээлээр нөхөж байв. БНМАУ, ЗСБНХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрээр батлан хамгаалах хэрэгцээнд урьд өмнө Монголын талд олгосон урьдчилгаанаас төлж дуусаагүй байсан 94,226,658 төгрөгийн өрийг 1930-аад оны эхээр шийдвэрлээд энэ чиглэлээр санхүүгийн тусламжийг үзүүлэх шинэ хэлбэрт шилжжээ. 1930-аад онд БНМАУ-ын батлан хамгаалахад зориулсан төсвийн зардлын 30 орчим хувийг ЗХУ-аас үзүүлж байсан цэргийн буцалтгүй тусламж, зээллэгээр хангаж байв. Энэ нь Халхын голын байлдааны өмнөх болон дэлхийн дайны жилүүдэд МАХЦ-ийг бэхжүүлэх бололцоог БНМАУ-ын Засгийн

өөрийгөө илчлэх тушаалын дагуу жирийн цэргээс Бүх цэргийн жанжин, байлдагчаас маршал, малчин ардаас пийшин баригч хүртэл олон зуун хүн эхлээд Ж.Лхүмбийн, дараа нь Гэндэн-Дэмид, Дамба-Найдангийн эсэргүү байгууллагын гишүүн, хань хамсаатан, тэдний гэр бүл хэмээгдэн өртсөн юм. Тэдний дотор халх, буриад, казах, дөрвөд болон Орос, Хятад улсын харьяат зэрэг Монголд оршин сууж байсан үндэстэн, ястнуудын төлөөлөгчид бүгд байв. Энэхүү хэлмэгдүүлэлтэд Цэргийн яам, Жанжин штаб, Улс төрийн газрын дарга, орлогч, тэдгээрийн газар, хэлтсийн дарга, орлогч нар, дивиз, бригад, хороодын удирдлага 2-5 удаа баривчлагдсан байна.

Цэргийн түүхч, доктор Б.Даваасүрэн агсны судалгаагаар МАХЦ-ийн

БИДНИЙ НЭГ

"Танд энэ өдрийн мэнд хүргэе. ЗХУ-ын дөрвөн удаагийн баатар, БНМАУ-ын баатар, ЗХУ-ын маршал, Улаанбаатар хотын хүндэт иргэн Г.К.Жуковын дурсгалын музейд тавтай морил" хэмээн инээмсэглэн угтах нүүрэндээ

нь талархаж явдаг.

Шинэхэн дэслэгч байлдагчдад соёл хүмүүжлийн ажлыг явуулна гэдэг тухайн үед хамгийн бэрх даваа байсан гэдэг. Юу хийхээ, юу хэлэхээ мэдэхгүй, хаанаас ажлаа эхлэхээ ойлгохгүй шинэхэн дэслэгчийн

улсын байгууллагатай хамтран "Гэр бүлийн үндсэн ойлголт", "Хосуудын харилцааны зөрчил, тэдгээрийг зохицуулах нь", "Сэтгэл татам эхнэр, нөхрийн эрхэм чанар, эхнэр, нөхрийн харилцааны үндсэн зарчим", "Хүүхдийн сэтгэл зүй ба танин

эрдэм шинжилгээний ажилтан О.Дарханчимэг нь түүний багш бөгөөд байнгын холбоотой байж зааварчилгаа, зөвлөгөө өгч ажилладаг гэнэ. Түүнчлэн Г.К.Жуковын дурсгалын музей байрлах ойр орчимд амьдардаг маш олон ахмад

түүртэлгүй, мэдэхгүй, чадахгүй зүйл ховор байсан юм билээ. Харин одоогийн ажлаа хүлээн авснаас хойш маш олон зүйлд суралцсан ажээ. Тэдгээрээс хамгийн чухал нь соёлыг танин мэдэх, хүнтэй харилцах харилцааны соёлд суралцахад

Д.Амартайван: АЖЛЫГ ДУРЛАЖ ХИЙХ САЙХАН

галтай, нүдэндээ цогтой энэ бүсгүйг хошууч Д.Амартайван гэдэг. Г.К.Жуковын дурсгалын музейн эрхлэгч, тайлбарлагч тэрээр удам дамжсан цэргийн хүн бөгөөд гадаад хэлний багш-орчуулагч мэргэжилтэй. Түүний ажлын анхны гараа Хилийн цэргийн 0101, 0108 дугаар ангиудад бичиг баримтын шалгагч, хилчин шалгагч, орчуулагч-шалгагчаар эхэлж байсан. "Монгол Улсын дархан хилийн манаанд алхаад марш" хэмээх үүрэг авсан тэр үеэс ээж, аав, эх орон гэдэг зүйл хэчнээн үнэ цэнтэй, эрхэм болохыг ойлгохын зэрэгцээ эх оронч байх, эх орноо хайрлах эгэлхэн бөгөөд агуу үзлийг өөртөө бий болгож чадсан юм. Учир нь хүн бүрийн унтаж байдаг цагаар, олон цагийн турш хилийн зурвас дагуух газарт алхан хилийн манааны үүрэг гүйцэтгэх хугацаанд тэрээр "миний" гэх тодотголтой бүхий л зүйлийнхээ амгалан тайван, аюулгүй байдлын төлөө, үнэнчийн тангараг өргөн үүрэг гүйцэтгэдэг хилчин байсан. Хэдий бага хугацаанд Хилийн байгууллагад харьяалагдан үүрэг гүйцэтгэж байсан ч тэр бээр одоо хэр нь хилчин охид, хөвгүүдийн талаар ярихдаа омогшиж, тэднийг хайрлахын зэрэгцээ Монгол Улсын хил өнө мөнхөд аюулгүй тайван байх болтугай хэмээн сүслэн залбирдаг нэгэн.

өөдөөс хараа салгалгүй ширтэх байлдагчдын өмнө тэр офицер болсон түүхтэй.

Түүний дараагийн томилгоо нь Зэвсэгт хүчний 330 дугаар ангид соёл хүмүүжлийн офицерыналбан тушаал байлаа. Өнөөгийн Бригадын генерал С.Дашзэвэгийн удирдлагад дөрвөн жил ажиллахдаа би ажилдаа мэргэшсэн гэж боддог хэмээн тэрээр дурссан. Энэ, тэр гэж зааж хэлэмгүй их зүйлийг сурсан газар бол яахын аргагүй Зэвсэгт хүчний 330 дугаар анги маань байсан. Удирдагч хүн, цэргийн хүн ямар байх, хамт олон хэрхэн төлөвших зэргийг мэдэрч, нүүдлийн шувуу шиг хоёр газар амьдарч байсан миний бие гэр бүлээ хэрхэн авч явах зэрэг энгийнээс ээдрээтэй олон зүйлийг тухайн ангид ажиллахдаа сурсан гэж тэр өгүүллээ. Миний хоёр охин Дархан, Улаанбаатарын замд мөн ч их унтаж явсан даа хэмээн дурсан ярихад нь цэргийн хүний даваа ёстой давааныхаа нэгийг нь ардаа хийжээ хэмээн эрхгүй бодогдож билээ.

Тус ангид ажиллахдаа бие бүрэлдэхүүнтэй зохиох соёл хүмүүжлийн ажлыг төлөвлөн зохион байгуулах, сургалт бэлтгэлийн чанар, үр нөлөөг дээшлүүлэх, хууль, эрх зүйн мэдээлэл, зөвлөгөөгөөр хангах, чөлөөт цагийг нь зөв боловсон өнгөрүүлэх, бие



мэдэхүйн онцлог" сэдвээр сургалтыг анхлан зохион байгуулж байв. Мөн ангийнхаа 20 орчим цэргийн алба хаагчидтай орос хэлний анхан шатны дамжааг зохион байгуулж амжилттай төгсгөжээ.

Түүний дараагийн томилгоо нь Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн Иргэн-цэргийн харилцааны офицер. Энэ үед хамгийн чухал нь юу байв хэмээн асуухад "Гэр бүлтэйгээ нэг дор хамт байх" хэмээн торолгүй хариулсан. Энгийн ч гэсэн энэ хариулт цэргийн гэх тодотголтой олон арван алба хаагчдын хүсэл мөрөөдөл, зорилго гэлтэй. Тухайн ангид ажиллах хугацаандаа тэрээр Нийслэлийн Баянгол, Сүхбаатар дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдад "Монгол цэрэг-Дэлхийн цэрэг" сэдэвт сурталчилгааны ажлыг хоёр үе шаттайгаар амжилттай зохион байгуулжээ. Мөн БХЯ, ЗХЖШ, ЦДБЭЧ-аас жил болгон зохион байгуулдаг "Хийморь өөдөө Монгол цэрэг" уламжлалт тэмцээнд баг тамирчдаа амжилттай бэлтгэн оролцуулж 2014 онд тусгай байр, 2015 онд тэргүүн байрт шалгарсан бөгөөд энд түүний гүйцэтгэсэн үүрэг тун их юм. Мөн тэрээр тус ангид ажиллах хугацаандаа Батлан хамгаалахын сайдын тушаалаар Халхын голын байлдааны ялалтын 75 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдсан Монгол Улс, Оросын Холбооны Улсын залуучуудын хамтарсан "Дайчин нөхөрлөлийн замаар" тойрон аялалд орчуулагчаар томилогдон үүргээ үлгэр жишээ биелүүлснээр ЗХЖШ-ын даргын тушаалаар үндсэн цалин 30 хувиар хоёр сар нэмэгдүүлэн шагнасан нь түүний хувьд ихээхэн урам зориг өгсөн үйл явдал болжээ. Энэхүү аяллаас ирээд нэг их удаагүй байтал түүнийг БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга дуудаж Г.К.Жуковын дурсгалын музейд эрхлэгч, тайлбарлагчаар томилжээ. Анх томилогдож байхдаа үнэндээ юу хийхээ мэдэхгүй байлаа хэмээн тэрээр нуулгүй хэлсэн. Ангиас ангийн хооронд томилогдоход хийх ажилдаа нэг их тордоггүй байсан бол энэ ажил тэс өөр ажээ. Нэг л их "харанхуй" хүн явж байхад тухайн үед Монгол цэргийн музейн захирал байсан хурандаа Г.Золзаяа 14 хоногийн чөлөө олгон Чойжин ламын сүм музейтэй танилцаж, дадлага хийх үүрэг өгсөн. Тус музейд очиход 26 настай О.Дарханчимэг гэх бүсгүй музейн анхны "А"-г нь зааж өгснөөр хаана, юу хийхээ мэдэж яг л өөрийнх нь хийх ажил юм шиг хүлээн авч ажлаа эхлүүлж байсан аж. Өдгөө Чойжин ламын сүм музейн

Г.К.Жуковын хөшөө болон музейн үзмэрүүдийн талаарх алдаа дутагдлыг нь хэлж орж ирдэг бөгөөд өдгөө тэдгээр ахмадуудтайгаа хэдийнээ найз болж тэднийхээ саналыг ажилдаа тусгахыг хичээдэг

чиглэгдсэн бөгөөд энэ талаар өөрийгөө нэг шат ахисан гэж хэлж болохуйц гэнэ. Түүнчлэн түүнийг энэхүү албан тушаалд томилогдоход болон ямар нэг ажлыг зохион байгуулахад түлхэц болсон хамгийн чухал

Анх томилогдож байхдаа үнэндээ юу хийхээ мэдэхгүй байлаа хэмээн тэрээр нуулгүй хэлсэн. Ангиас ангийн хооронд томилогдоход хийх ажилдаа нэг их тордоггүй байсан бол энэ ажил тэс өөр ажээ. Нэг л их "харанхуй" хүн явж байхад тухайн үед Монгол цэргийн музейн захирал байсан хурандаа Г.Золзаяа 14 хоногийн чөлөө олгон Чойжин ламын сүм музейтэй танилцаж, дадлага хийх үүрэг өгсөн. Тус музейд очиход 26 настай О.Дарханчимэг гэх бүсгүй музейн анхны "А"-г нь зааж өгснөөр хаана, юу хийхээ мэдэж яг л өөрийнх нь хийх ажил юм шиг хүлээн авч ажлаа эхлүүлж байсан аж.



Тэрээр Зэвсэгт хүчин хэмээх их айлаар 2004 оноос овоглож эхэлсэн. Тухайн үед амьдралын шаардлагаар хил хамгаалах байгууллагаас гарч Зэвсэгт хүчинд алба хаах өргөдлөө өгөхөд ЗХЖШ-ын Хүний нөөцийн хэлтэст ажиллаж байсан дэд хурандаа О.Чадраабал, Г.Үнэнбаяр нар дуртайяа хүлээн авч Зэвсэгт хүчний 013 дугаар ангид соёл хүмүүжлийн зааварлагчаар томилж байжээ. Тэр үед ҮБХИС-д улс төрийн ажилтан, соёл хүмүүжлийн мэргэжлээр төгсгөдөггүй байсан учир "Гадаад хэлний өндөр мэдлэгтэй мэргэжилтэн Зэвсэгт хүчинд хэрэгтэй" хэмээн уриалгахан хүлээн авсанд тэрээр одоо хэр

бялдрыг нь чийрэгжүүлэх, сэтгэл зүйн бэлтгэлийг нь дээшлүүлэх зэрэг ажлыг амжилттай удирдан хэрэгжүүлж, биелэлтэд нь хяналт тавихад түлхүү анхаарч ажиллажээ. Мөн соёл хүмүүжлийн болон социологийн судалгааны дүн, мэдээг тогтмол гаргаж, үр дүн, цаашдын зорилтыг нь тодорхойлон хууль тогтоомж, цэргийн дүрмийн хэм хэмжээг ёсчлон сахих үүргээ ч сайн гүйцэтгэхийн зэрэгцээ санаачилгатай, үр дүнтэй ажиллаж ирсэн нь түүний хийж хэрэгжүүлсэн олон ажлаас нь харагддаг. Тухайлбал, Энхийг сахиулагчдын гэр бүлийнхнийг дэмжих өдөрлөгийг зохион байгуулж, Дархан-Уул аймаг дахь "Дэлхийн зөн Монгол" олон

болжээ. Түүнчлэн тэрээр энд ажиллах хугацаандаа "Зэвсэг нэгт ахан дүүс", "Туркменистан улсын урчуудын", "Зөвлөлт Холбоот Улсын Баатар эмэгтэйчүүд", "Эх орны дайны жилүүдэд фронт командлагч нар", "Аугаа их Эх орны дайны жилүүдэд Г.К.Жуковын үүрэг, оролцоо", "Аугаа их Эх орны дайны жилүүдэд монголын ард түмэн бүхнийг фронтод, бүхнийг ялалтад" зэрэг олон тооны үзэсгэлэнг дэлгэжээ. Тэрээр энэ бүхнийгээ би энэ ажилд дурласан. Энэ музей, үзэсгэлэн, үнэт өв гэдэг зүйлд би дурласан, тиймдээ ч бүх зүрх сэтгэлээ зориулан ажиллахыг хичээдэг гэв. Мөн үндсэн ажлаасаа гадна өөрийнхөө шинээр сурсан, дадаж буй ажлаа илтгэн харуулсан хүүхэд, залуучуудад зориулсан хоёр номыг бүтээсэн ба энэ нь түүнийг ажилдаа эзэн болсныг нь илтгэн харуулж буйн жишээ юм. Г.К.Жуковын талаар маш олон уран бүтээл, гарын авлагууд байдаг хэдий ч хүүхдүүдэд зориулсан, тайлбарт зурагт ном хараахан байдаггүй байсан бөгөөд энэхүү орон зайг харж тус бүтээлүүдээ гаргасан нь ихээхэн олзуурхуштай юм.

Үүнээс харахад, тэрээр Зэвсэгт хүчний нэг ангиас нөгөөд томилогдон ажиллахад нэг их

зүйл бол орос хэлний мэдлэг юм. Түүний унаган гэж хэлж болохуйц орос хэлд сургасан хүн бол ээж нь аж. Орос хэлний багш мэргэжилтэй ээж Л.Бурмаа нь багаас нь орос хэлээр үлгэр уншуулан зөв бичих болон ярианы дүрэмд сургасан бөгөөд түүний үр хүүхдүүддээ зааж сургасан тэр л эрдэм тэдний нэг насны хоолоо олж идэх мэдлэг ярианы бүхнийг фронтод, бүхнийг ялалтад" зэрэг олон тооны үзэсгэлэнг дэлгэжээ. Тэрээр энэ бүхнийгээ би энэ ажилд дурласан. Энэ музей, үзэсгэлэн, үнэт өв гэдэг зүйлд би дурласан, тиймдээ ч бүх зүрх сэтгэлээ зориулан ажиллахыг хичээдэг гэв. Мөн үндсэн ажлаасаа гадна өөрийнхөө шинээр сурсан, дадаж буй ажлаа илтгэн харуулсан хүүхэд, залуучуудад зориулсан хоёр номыг бүтээсэн ба энэ нь түүнийг ажилдаа эзэн болсныг нь илтгэн харуулж буйн жишээ юм. Г.К.Жуковын талаар маш олон уран бүтээл, гарын авлагууд байдаг хэдий ч хүүхдүүдэд зориулсан, тайлбарт зурагт ном хараахан байдаггүй байсан бөгөөд энэхүү орон зайг харж тус бүтээлүүдээ гаргасан нь ихээхэн олзуурхуштай юм.

Түүний ханийг Т.Цахиур гэдэг бөгөөд "Сайхан ханийн үлгэр жишээ болсон бурхан шиг ханьтай, би азтай эмэгтэй" хэмээн тэрээр ярианыхаа төгсгөлд хэлсэн. Ийм л эгэл даруухан, хүлээсэн үүргээ мадаггүй биелүүлдэг эрхэм зан чанартай бүтээлч, авьяаслаг хүмүүсээр Монгол Улсын Зэвсэгт хүчин арвин юм.

Хошууч Д.ОЮУНГЭРЭЛ

ХОШУУЧ ГЕНЕРАЛ Ж.ЦЭНД-АЮУШИЙН МЭНДЭЛСНИЙХ НЬ 100 ЖИЛИЙН ОЙД

ТӨР, ЦЭРГИЙН НЭРТ ЗҮТГЭЛТНИЙ ТАЛААР ӨГҮҮЛЭХҮЙ

Хошууч генерал Ж.Цэнд-Аюуш нь 1920 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр Сайн ноён хан аймгийн Сүжигт бэйсийн хошуу, одоогийн Архангай аймгийн Хотонт сумын "Бургалтай" хэмээх газар эцэг Дэлэгийн Жамц, эх Дамдинжавын Бал нарын гэр бүлд отгон хүү нь болон мэндэлсэн байна. Тэр бээр 19 (20) настайдаа Бүх цэргийн жанжны 1940 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 19 дүгээр тушаалын дагуу цэргийн албанд татагдаж, Баянтүмэн дэх 5 дугаар морьт дивизийн Их бууны дивизионд цэрэг, бага дарга, 1941 оны 9 дүгээр сараас 1942 оны 5 дугаар сар хүртэл мөн дивизийн Их бууны дивизионд сумангийн комиссар (улс төрийн удирдагч)-ын албан тушаалд томилогдож, эр цэргийн албаа нэр төртэй хаасан нь ирээдүйн Ардын цэрэг, Ардын Армийн Улс төрийн ажилтны замнал, үйл хэргийнх нь эхлэл болсон түүхтэй. Түүнчлэн Ж.Цэнд-Аюуш цэргийн албанд хүчин зүтгэх үедээ 1940 оны 12 дугаар сарын 14-ний өдөр 5 дугаар дивизийн Их бууны дивизионы намын үүрт орлогч гишүүн, 1941 оны 8 дугаар сард жинхэнэ гишүүнээр элссэн төдийгүй мөн ангидаа намын үүрийн дарга, дивизийн намын товчооны тэргүүлэгч гишүүнээр сонгогдож, цэргийн доторх нам, улс төрийн удирдах албанд улам бүр дадлагажин суралцжээ.

Ж.Цэнд-Аюуш 1942-1943 онд Цэргийн Ерөнхий сургуулийн дэргэдэх нэг жилийн хугацаатай хурдавчилсан курс буюу улс төрийн ангид сургагчаар элсэж, онц дүнтэй суралцаж төгссөн ба маршал Х.Чойбалсангийн нэрэмжит 300 төгрөгөөр шагнагдсан нь сурч боловсрох, ахиж дэвших хүсэл сонирхлынх нь бас нэгэн бахархал байсан юм. Ийнхүү түүний эрдэм, чадвар бага залуугаас нь танигдаж, удалгүй Бүх цэргийн жанжны 1943 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн 086 дугаар тушаалаар Улс төрийн удирдагч цолоор шагнуулан 5 дугаар дивизийн Холбооны сумангийн улс төрийн удирдагчийн албан тушаалд томилогдсон бол 1943 оны 5 дугаар сарын 1-ний өдөр маршал Х.Чойбалсангийн тушаалаар ахлах дэслэгч цол шагнагдсан. Ж.Цэнд-Аюуш нь 1945 оны Чөлөөлөх дайнд Баянтүмэний 5 дугаар морьт дивизийн 28 дугаар морьт хороонд Намын товчооны даргаар томилогдон оролцсон Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн юм. Хожим хошууч генерал Ж.Цэнд-Аюуш "1945 онд 3 сар шахам хугацаанд Цагаан хэрэм, Долоннуур, Жэхэ хотуудаар явсан. Миний бие цэрэг, улс төрийн ба ерөнхий боловсролоор бэлтгэл муутай тул сургуульд суралцахыг хүсдэг. Намын ба хууль цаазын ажилд сонирхолтой..." гэх зэргээр дурсан бичсэн нь буй. Үнэхээр ч хошууч генерал Ж.Цэнд-Аюуш ажил, албаныхаа зэрэгцээ 1947-1949 онд Намын шинэ хүчний дээд сургууль, 1955-1959 онд ЗХУ-ын Коммунист намын Төв Хорооны дэргэдэх Намын дээд сургуульд тус тус амжилттай суралцан төгсөж, нам, улс төр, цэргийн хэргийн мэдлэг, боловсролоо ямагт дээшлүүлсээр ирсэн юм. Тухайн үеийн Цэргийн явдлын яам, Цэргийн Улс төрийн газрын удирдлагаас Ж.Цэнд-Аюушийн эрхэлсэн ажил, мэргэжил, дадлага, туршлагыг нь сайтар харгалзан үзсэний учир 1945 оноос мөн дивизийн Их бууны хороонд Намын товчооны дарга, дивизийн Улс төрийн хэлтэст намын ажлын зааварлагч, 1947 оноос ЦЯЯ-ны Улс төрийн газрын Зохион зааварлах хэлтэст мэдээ боловсруулагч, хэлтсийн дарга, 1951 оноос Улс төрийн газарт Шинэ хүчний хэлтсийн орлогч, 1952 оноос маршал Х.Чойбалсангийн нэрэмжит мотомеханикжуулсан 6 дугаар бригадын Улс төрийн хэлтсийн дарга, мөн бригадын улс төрийн орлогч бөгөөд Улс төрийн хэлтсийн дарга, 1953 оноос Цэргийн улс төрийн газрын даргын орлогч бөгөөд нам, эвлэлийн ажлыг удирдах хэлтсийн дарга 1954 оноос Ардын Армийн Улс төрийн газрын орлогч даргаар тус тус томилжээ.

Хошууч генерал Ж.Цэнд-Аюуш 1940-өөд оны дунд үеэс 1950-иад оны дунд үе хүртэлх хугацаанд Ардын Армийн Улс төрийн газрын шат шатны бүхий л харууцлагатай удирдах албан тушаалд томилогдож, нэр төртэй хашсан нь цэргийн доторх нам, улс төрийн ажлын өндөр боловсрол, удирдан зохион байгуулах төрөлхийн авьяас чадвар, дадлага, туршлага нь нэгэнтээ хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд хүрснийг тодорхой харуулсан аж. Тийм ч учраас хошууч генерал Ж.Цэнд-Аюуш нь МАХН-ын Төв Хорооны Улс төрийн товчооны тогтоол болон Улсыг батлан хамгаалах яамны сайдын тушаал, шийдвэрийн дагуу Ардын цэргийн Улс төрийн газар (АЦУТГ)-ын даргаар 10 шахам жилийн хугацаанд буюу 1954-1955, 1959-1960, 1962-1969 онд нийт 3 удаа томилогдон ажилласан нь үе үеийн цэрэг, улс төрийн ажилтан, удирдах бүрэлдэхүүний ажил, албаны түүхэнд нэгэн содон үйл явдлын нэгэнд зүй ёсоор үнэлэгдэн үлдэх нь



дамжиггүй.

Тэр бээр БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл (СнЗ)-ийн 1965 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 139 дүгээр тогтоолоор "Хошууч генерал" хэмээх цэргийн эрхэм дээд цол хүртсэн цэргийн нэрт зүтгэлтэн юм. Зарим түүхэн баримтыг сөхвөл, АЦХЭЯ-ны сайд бөгөөд Ардын Армийн командлагч, хурандаа генерал Ж.Лхагвасүрэнгээс БНМАУ-ын СнЗ-ийн дарга Ю.Цэдэнбалд явуулсан 1965 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн №1/1066 тоот албан бичигт "Ардын Армийн Улс төрийн газрын дарга, хурандаа Ж.Цэнд-Аюуш 25-аас 20 шахам жилд нь Ардын Армид нам, улс төрийн ажил хийж, энэ хугацаанд цэргийн доторх нам, улс төрийн ажлыг өөрийн өмнө тавигдсан зорилтыг биелүүлэхэд чиглүүлэн чадамгай зохиож байна. Ж.Цэнд-Аюуш нь даалгасан ямар ч үүргийг биелүүлэх авьяас чадал, мэдлэг, боловсролтой, нэр хүнд бүхий удирдах ажилтны нэг учир Майн баярыг тохиолдуулан хошууч генерал цол шагнуулахаар өргөн мэдүүлж, тодорхойлолтыг хавсаргав" гэсэн байна.

Хошууч генерал Ж.Цэнд-Аюушийн АЦУТГ-ын даргаар ажилласан цаг үе бол XX зууны Монголын цэрэг, армийн түүхэн хөгжлийн хувьд улс төр, байлдааны бэлтгэл сургуулийг шинэ шатанд гаргах, анги, салбаруудын бүх байлдагч, дарга бүрийн сэтгэл зүй, байлдах чадвар, зөвсөг, техник, сахилга бат, зохион байгуулалтыг улам бүр боловсронгуй болгох олон талын бодлого, зорилтыг дэвшүүлсэн нэн амаргүй, хүндрэл бэрхшээл тулгарсан, өөрчлөлт шинэчлэлийн хамгийн хариуцлагатай он жилүүд байснаараа онцлог байв. Энэ тухайд БНМАУ-ын СнЗ-ийн дарга Ю.Цэдэнбал 1968 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн Ардын Армийн Намын XXII бага хуралд оролцож "Ардын Армийн дайчдын чухал зорилт" хэмээх хэлсэн үгэндээ "Орчин үеийн дайн, цэрэг дайчдын санаа сэтгэл, бие бялдрын онц хүч чадалтай байхыг онцгой их шаардаж байгаа учир орчин үеийн дайнд цэргүүдийн санаа зоригийн роль хэмжээлшгүй нэмэгдэж байгааг санах ажиллах хэрэгтэй. Цэрэг дайчид туйлын зохион байгуулалттай, өндөр сахилга баттай, гойд түргэн ажиллагаатай, үүргээ агшин зуур нягт нямбай биелүүлдэг, ялж дийлэхийг ямагт эрмэлздэг, дайн, тулалдаанд тулгарах бүхий л бэрхшээлийг тэсвэртэй давдаг, эрэлхэг зоригтой, авхаалж самбаатай байх явдал шаардагдаж байна. Цэрэг нэг бүрийг хэргийн нөхцөлд өдөр, шөнө ялгалгүйгээр ямар ч цаг үед үүргээ чадамгай биелүүлдэг, үй олноор хөнөөх зэвсэг хэрэглэх үед чадамгай эрс шийдвэртэй ажиллаж чаддаг болох ёстой. Энэ бол орчин үеийн байлдааны нарийн нөхцөлд байлдаж чадах дадлагыг энх тайван цагт дайчдаар эзэмшүүлэх хэрэгтэй гэсэн үг юм" гэж онцлон тэмдэглэж байв. Хошууч генерал Ж.Цэнд-Аюуш юуны өмнө цэрэг дайчдын сэтгэл зүй, соёлч боловсон байдал, сахилга бат, хүмүүжил төлөвшил, бичиг үсэг, соён гэгээрүүлэх чиглэлд илүүтэй анхааран ажиллажээ. Тэр бээр өөрийн эрхэлсэн ажил алба, эрх, үүргийн хүрээнд анги, салбарын улс төр, байлдааны бэлтгэлийг чанарын өндөр түвшинд зохион байгуулах, онол, орос хэлний мэдлэг, сургуулийн группийн удирдагчдын ажлын чанар, зохион байгуулалтыг сайжруулах, тэдгээрийн сэтгэл зүй, заах аргын ур чадварыг нэмэгдүүлэхээс гадна МАХЦ-ийн ансамбльд мэргэжлийн хүмүүсийг шилж сонгон шалгаруулах замаар томилон ажиллуулах, хөгжмийн зэмсэг, хэрэгслээр хангах зэрэг цэргийн улс төр, байлдааны бэлтгэл сургалтын олон

талын бүтээлч ажил, арга хэмжээнд онцлон анхаарч, удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллаж байв. Мөн цэрэг, дайчдыг бичиг үсэгт сургах, тэднийг соён гэгээрүүлэх ажилд анхаарч, 1955 оны 1 дүгээр сард болсон "Улаан од сонины уншигчдын бага хурлын дүнгээр авах арга хэмжээний тухай" тушаалдаа "Сонинд хэвлэгдсэн тэргүүний туршлагаудыг дэлгэрүүлэх ба сонины шүүмжлэлээр илэрсэн дутагдлыг засах арга хэмжээ авч, түүний хариуг сонины редакцияд заавал ирүүлэх, сонин хэвлэлд өөрийн биеэр улс төр, онолын, цэргийн хэргийн ба туршлагын материал мэдээг тогтмол бичих, сонины газар уншигчдаас сонирхох асуудал ирүүлэх, сонинд хэвлэлт, зөвлөгөөн өгөх явдлыг тогтмол зохиох зэрэг тухайн үедээ шинэлэг санал, санаачилгыг гаргаж байв.

АЦУТГ-ын дарга, хошууч генерал Ж.Цэнд-Аюуш нь цэргийн нэрт зүтгэлтний хувьд үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнол, эх оронч үзэл, хүмүүжлийн үнэ цэн, ач холбогдлыг өсвөр хойч үедээ танин мэдүүлж өвлүүлэх, ахмад, залуу үеийнхний залгамж холбоог бэхжүүлэх үүднээс 1960 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн "Цэргийн үзэсгэлэнгийн зүйлүүдийг тоолох комиссыг томилох тухай" 21 тоот тушаалдаа "Ардын цэргийн түүх, дурсгалын эд хогшил нь нарийн тоо бүртгэл, тодорхой хаяггүй явж ирсэн учир янз бүрийн эд хогшил, гадаад орнуудаас бэлгэнд ирсэн зүйлүүдийг нарийн тоо ширхэг ба үнэ цэн, тусгай данстай болгох"-ыг онцлон зааж хэрэгжүүлсэн нь өнөөгийн Монгол цэргийн музейн сан хөмрөгийг бүрдүүлж, олон нийтийн хүртээл болгох хэрэгт үнэтэй хувь нэмэр оруулсан төдийгүй 1966 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр "Монголын Ардын Армийн өнөөгийн зорилт" хэмээх илтгэлдээ музей байгуулах тухай саналыг анхлан гаргасан ажээ. Хошууч генерал Ж.Цэнд-Аюушийн санаачлан зохион байгуулж, бүтээн байгуулсан олон тал ажил үйлсийг өдгөө ч хамтран зүтгэгч, анд нөхдөөс нь эхлээд хойч үеийнхэн, эрдэмтэн

зүтгэлтэй ажилласан нь мэдэгдэнэ. Түүнчлэн хошууч генерал Ж.Цэнд-Аюушийн цэргийн улс төрийн ажилтны хувьд өсөн дэвшсэн замнал, үйл хэргийг дараах байдлаар үечлэн үзэж болохоор байна. Үүнд:

1. 1920-1940 он. Халамжит эцэг, эхийнхээ отгон хүү болон өсөн торниж, эрийн цээнд хүрсэн амьдралын хамгийн дурсамж дүүрэн бага, залуу насны үе (20 жил);

2. 1940-1954 он. Цэргийн албанаа анхлан татагдаж, улс төрийн ажилтны өндөр мэдлэг, боловсрол, дадлага, туршлага хуримтлуулсан үе (14 жил);

3. 1954-1969 (1971) он. Ардын цэрэг, Ардын Армийн УТГ-ын даргын удирдах албан тушаалд томилогдож, цэргийн доторх нам, улс төрийн ажлыг удирдлага, зохион байгуулалтаар ханган бэхжүүлж, Монголын төр, цэргийн нэрт зүтгэлтний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн үе (15/17 жил) болно.

АЦУТГ-ын дарга, хошууч генерал Ж.Цэнд-Аюушийн амьдрал, үйлсийг түүнтэй хамтран зүтгэсэн мөрдэс нэгт хамтран зүтгэгч анд нөхөд, төр, цэргийн зүтгэлтнүүдээс салангид авч үзэх аргагүй билээ. Өөрөөр хэлбэл, хошууч генерал Ж.Цэнд-Аюуш олон арван жилийн туршид нам, улс, цэргийн хэрэгт нэгэн үзүүрт сэтгэлээр хичээн зүтгэж ахуйд биеийн эрүүл мэндийн хувьд эрхгүй доройтож байсан удаатай. Ийм хүнд бэрх нөхцөлд АЦХЭЯ-ны сайд бөгөөд Ардын цэргийн командлагч Ж.Лхагвасүрэн МАХН-ын Төв Хорооны Гадаад харилцааны хэлтсийн эрхлэгчид 1965 оны 5 дугаар сард илгээсэн албан бичигтээ "ЗХУ-ын БХЯ-ны сайд, маршал Р.Я.Малиновский Ардын Армийн УТГ-ын дарга, хошууч генерал Ж.Цэнд-Аюушийг гэр бүлийн хамт ирж амрахыг урьсан юм. Энэ урилгын ёсоор хошууч генерал Ж.Цэнд-Аюушийг ЗХУ-д явуулж, амраахын хамт эмчлүүлэх шийдвэр гаргаж өгөхийг хүсье" гэсэнээс гадна түүнийг олон цагаар ажиллуулахгүй байх, долоо хоногт 2 өдрийн амралт олгох зэргээр анхаарч байжээ. Энэ



БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгч гишүүд: Өвөр эгнээнд, зүүн гараас: С.Батаа, Ж.Самбуу, Ц.Готов, арын эгнээнд Г.Чимэд, Ч.Пүрэвжав, С.Удвал, хошууч генерал Ж.Цэнд-Аюуш, Д.Ядамсүрэн. 1966 он

судлаачид хүртэл онцлон тэмдэглэсэн нь олонтоо. Тэдгээрээс заримыг дурдвал, Ардын Армийн Улс төрийн газрын орлогч дарга, хошууч генерал Т.Алтангэрэл "Цэргийн шинэ зэвсэг, техникийг богино хугацаанд мастерын ёсоор эзэмшүүлэх хөдөлгөөнийг анги, салбарт өрнүүлэх, анхны сумаар байг сөнөөх, цэргийн хос мэргэжил эзэмших хөдөлгөөнийг ХЗЭ-ээс арми даяар өрнүүлсэн. Техник, пуужингийн ба радио техник, их буу, танк, холбооны шинэ хэрэгслийг дайчид 7-10 сарын дотор эзэмшиж байлаа" гэсэн бол "Цэргийн улс төр, соёл хүмүүжлийн ажилтны нэгдсэн эвлэл" ТББ-ын тэргүүн, бэлтгэл хурандаа Б.Жуваа "Ардын Армийн Улс төрийн газрыг хамтын удирдлагын зарчимд шилжүүлж, Улс төрийн товчоог байгуулсан, Монгол цэргийн музейг байгуулан дайчдын хөшөө дурсгалыг бүтээх, салбарын захирагчийн улс төрийн орлогчийн орон тоог 1964 оноос сэргээсэн, салбарын Сүхбаатарын тасалгаа бүрийг "Баян хуур" хөгжимтэй болгож, Армийн хэмжээнд баян хуурчдын түр курсийг байгуулан хөгжимчдийг бэлтгэсэн, Армийн бодлого, зорилтыг сурталчлан таниулах зорилгоор 1-2 аймагт сурталчилгааг хэрэгжүүлж, Архангай аймгаас эхлүүлсэн" зэрэг олон төрлийн ажил, санал, санаачилгыг нь онцлон тэмдэглэжээ.

Дээрхээс үзэхэд, АЦУТГ-ын дарга, хошууч генерал Ж.Цэнд-Аюуш цэрэг, дайчдын улс төр, байлдааны бэлтгэл сургуулийг юуны өмнө иргэн-цэргийн харилцаа, хамтын ажиллагаанд үндэслэн төрөл бүрийн чиглэлээр зохион байгуулж, тухайн үеийн нам, засаг, Ардын Армийн хэмжээнд тавигдсан бодлого, зорилтыг ханган биелүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулан, идэвх

бол хошууч генерал Ж.Цэнд-Аюушийн хамтран зүтгэгч гадаад, дотоодын анд нөхдөөс түүний ажил үйлс, дадлага, туршлагыг нь гүнээ хүндэтгэж, эрхэлсэн ажил албыг хэвийн гүйцэтгэх боломж, бололцоогоор ханган ямагт анхаарал хандуулж байсны бодит жишээ болохыг онцлон тэмдэглүүштэй.

Хошууч генерал Ж.Цэнд-Аюуш хэдийгээр биеийн эрүүл мэнд тааруу байсан ч өөрийн эрхэлсэн ажил, албаа нэр төртэйгээр үргэлжлүүлэн гүйцэтгэж, Ардын цэргийн хөгжилд хичээл зүтгэл, хувь нэмрээ зориулсан төдийгүй 1969-1971 онд Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтний хорооны анхны даргаар үр бүтээлтэй ажилласан юм. Түүний Ардын цэрэг, Ардын Армид он удаан жил, үр бүтээлтэй ажилласныг нь өндрөөр үнэлж Байлдааны гавьяаны улаан тугийн одон, Байлдааны гавьяаны одон, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон, "Алтан гадас" одон, ЗХУ-ын Улаан тугийн одон, Байлдааны медаль, В.И.Лениний мэндэлсний 100 жилийн ойн медаль болон бусад медалиар шагнажээ.

Эдгээрээс дүгнэхэд, МАА-ийн УТГ-ын дарга, хошууч генерал Ж.Цэнд-Аюуш нь XX зууны Монголын төр, цэргийн түүхэнд өөрийн нэр хүнд, байр сууриа баттай эзэлсэн, цэргийн хэргийн мэргэжил, өндөр мэдлэг, боловсрол, дадлага, туршлагаараа зүй ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн төдийгүй цэргийн нам, улс төрийн ажилтнуудын үлгэр дуурайл, бахархлыг төрүүлсэн нэрт зүтгэлтэн байсан юм.

ҮБХИС-ийн Аюулгүй байдлын дээд сургуулийн НХТ-ийн дарга, доктор (Ph.D), дэд профессор И.ЧИНБАТ

НАНДИН ДУРСАМЖ-ЦЭРГИЙН НӨХӨРЛӨЛ

АРМИЙН ЖАГСААЛААС АНД НӨХДӨӨ ОЛОВ

1990 оны 8 дугаар сарын 1-ний өдөр Сүхбаатарын болон Байлдааны гавьяаны улаан тугийн одонт, жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит Цэргийн Нэгдсэн Дээд Сургуулийн Ерөнхий цэргийн "Б" курсийг төгсөж БХЯ-ны сайдын тушаалаар МАА-ийн 150 дугаар ангид салааны захирагчаар томилогдож очлоо. Манай төгсөлтөөс Ерөнхий цэргийн "А" курсийг төгссөн Түмэнжаргал, Хүрэлбаатар, Ариунболд, Отгонболд, Батсүрэн, Батчулуун, манай курсээс Анхбаяр, Нямчулуун бид гурав, Улс төрийн курсээс Галбадрах, танкаас Баярсайхан, Жаргалсайхан нарын 12 дэслэгч тус ангид алба хаахаар томилогдож очсон юм.

Бидний 12 дэслэгчийг анги нэгдэж, Байлдааны туг гарч, мөн тэтгэвэрт гарах ахмадууд байлцан угтаж авсан. Ангийн захирагч, хурандаа Л.Доржсүрэн ангийн дайчин замналыг дурсаж тус ангид алба хаана гэдэг нь нэр төрийн хэрэг хэмээн тодотгоод, биднийг тус тусын салбарт нь хуваарилж билээ.

Миний хувьд 150 дугаар ангийн 1 дүгээр батальоны 2 дугаар ротод сургуулийн салааны захирагчаар хуваарилагдсан. Надтай хамт Ерөнхий цэргийн "А" курсийг төгссөн Д.Батчулуун хуваарилагдсан. Нөгөө салааны захирагчаар С.Отгонбаяр ажиллаж байлаа.

Ингээд тухайн үед хамтран ажиллаж байсан дарга болоод анд нөхдийнхөө талаарх дурсамжаа дэлгэж буй минь энэ билээ.

Ротын захирагч, ахмад Т.Хүрлээ

1990 онд салааны захирагчаар томилогдон ахмад Тогоогийн Хүрлээгийн удирдлагад ажилласан юм. 1990-1996 онд Т.Хүрлээ даргатайгаа хамт алба хаасан үе маань миний амьдралд онцгой дурсамжтай сайхан байсан. Цэргийн амьдралын жаргал, зовлонг эдэлж, халуунд халж, хүйтэнд нь хөрж, хатуу зөөлөн хосолсон жилүүдийн хамгийн сайн дарга, халамжлан хүмүүжүүлэгч, түшигтэй сайн нөхөр минь Т.Хүрлээ мөнөөсөө мөн. Хүрлээ дарга маань хүнлэг сайхан сэтгэлтэй, аавын хөвгүүдийг алаг үзэлгүй харьцдаг, зарчимч шаардлагатай, сахилга бат, ажлын хариуцлагатай, хэлсэн үгэндээ хүрдэг, цэргийн хэргийн өндөр мэдлэгтэй, жинхэнэ цэргийн дарга хүнд байх олон сайхан чанаруудыг цогцлоосон ховорхон хүн юм.

Биднийг хамт алба хааж байх үед манай улсын эдийн засаг сайнгүй, армийн албан хаагчдын амьдрал тааруу байсан юм. Энэ үед цэргийн ахуй хангамж хангалтгүй байсны дээр цэргийн алба хаах хугацаа богиносгож нэг жил болсон үе байв. Салаа, салбарын захирагч нарын ажлын ачаалал эрс нэмэгдэж, цалин хангамж нь хувийн амьдралд нь хүрэлцэхгүй хүндхэн байсан энэ үеийг эргээд бодоход бидний нөхөрлөл улам ойртсон байх. Цэрэг оргох, туха, цахилгаан тасрах, цэргийн байрны халаалт доголдох, тэр байтугай анги тэр аяараа хөлдөж байсан зэрэг хүндхэн үед бид хамтдаа байж албаа сайн хааж байснаараа өдгөө бахархдаг. Энэ бүх бэрхшээлийн үед Хүрлээ даргатайгаа байхад түшигтэй сайхан байдаг сан. Тэр үед амьдрал, ахуйдаа нэмэр болох үүднээс монголчууд Орос, Хятад руу наймаа арилжаанд их явдаг байв. Тэдний жишгээр С.Отгонбаяр, Д.Батчулуун бид 3 Орос руу наймаанд явж, Улаан талбайд зургаа татуулсан шигээ явж байхад ротын захирагч маань ар талаа даагаад хэдэн бор цэргүүдийнхээ хичээл сургалтыг нь тасалдуулалгүй байж л байдаг сан.

Хүрлээ дарга маань ажлын зохион байгуулалт сайтай, хариуцлагатай, бичгийн чадвар өндөр, цаг сайн барьдаг, аж ахуйн ажилд тооцоо сайтай гээд олон сайн чанартай чухамдаа биднийг үлгэрлэн дагуулдаг офицер байв.

Тэрээр өдөр бүрийн ажлын тэмдэглэлийг "яс" хөтөлдөг, тэр үед одоогийнх шиг тэмдэглэлийн дэвтэр ховор, кассын бүртгэл гэх мэт хүснэгтгүй зузаан, хатуу хавтастай том дэвтэрт өдөр бүрийн ажлаа нэг бүрчлэн бичнэ. Бичгийн хэлбэр гэж сайхан, дармалдаад байхгүй бичмэлээр тун, гаргацтай сайхан бичнэ. Заримдаа хийсэн ажлаа мартчихаад даргаас сарын өмнөх ажлаа асуухад нөгөө зузаан хүснэгттэй кассын бүртгэлээ гаргаж ирээд нөхөр Лхагвасүх тэдэн сарын тэдний өдөр тэр тийм ажил хийсэн байна гээд торох юмгүй хэлнэ.

Эргэн дурсахад, Хүрлээ даргынхаа аав Тогоо гуайг Баянхонгороос ирэхэд нь зорьж очин золгож байсан минь сайхан санагдаж байна. Бидэнд дурсах зүйл их байдаг. Эцэст нь нөхрийнхөө тухай товчхон тодорхойлбол, Баянхонгорын тос даасан зузаан бор ааруул шигээ "тос даасан" эр хүн дээ, миний дарга. Найдаж, итгэж, даатгаж болох сайн дарга, сайн ах, сайн найз, эрхэм нөхөр Т.Хүрлээдээ урт нас, удаан жаргал, сайн сайхны дээдлийг чин зүрхнээс хүсье.

Дашрамд, эрхэм нөхрийн курсийн анд нар болох жороо явдалтай Эрдэнэбат, жоохон хамартай Батсүх, түргэн ярьдаг Лхагвасүрэн, тус тас яриатай Баттулга, уран гартай Лхагвасүрэн, уужуу тайван Даваажав нар болон бусад нөхөд нь ажлын амжилт, сайн сайхныг хүсье. Азтай, одтой байгаарай гээд шүлгэн цацал өргөө.



Зураг дээр: Өвөр эгнээнд, зүүн гар талаас ахмад Н.Баяр, Т.Хүрлээ, арын эгнээнд ахлах дэслэгч Д.Батчулуун, С.Отгонбаяр, С.Лхагвасүх 2007.03

ТҮШИГТ НӨХӨР МИНЬ

Хүнлэг сэтгэлт эрхэм нөхөр Хүрлээтэй
Үүрэг хүлээсэн цэрэг байхдаа танилцлаа
Рот захирагчтайгаа тоот

өндөрлөгийг эзэлж явлаа
Лагерийн жижүүр хийж, хээр хөндийг
ээзгэнэж явлаа

Эрийн дээд эр хүнтэй
Ээ дээ мөн чиг сайхан нөхөрлөлөө
Дээдэс өвгөдийн ерөөл байлгүй
Эрдэм сайт хүний хүүтэй
Эгэлгүй сайхан нөхөрлөсөөр явна ...

Ротын улс төрийн орлогч, ахмад Н.Баяр

Салбарын улс төрийн орлогчоор Нацагийн Баяр ажиллаж байв. Тэр 1987 онд ЦНДС-ийн Улс төрийн ангийг төгссөн, манай ротод Налайхын нисэх бригадаас шилжиж ирсэн ахмад алба хаана. Салбарын улс төрийн орлогч маань дарга, цэрэг ямар ч хүнтэй харилцаа сайтай, бидний хэлдгээр "найраа сайтай" аргагүй л улс төрийн ажилтны есөн шид нь бүрдсэн хүн сэн. Малигар шар нүүрний үрчлээ бүхэн нь инээж байх шиг баясгалантай эр дээ. Одоо ч хэвээрээ л байна, хүний төрөлхийн араншин өөрчлөгддөггүй бололтой. Цэргүүдтэй ажиллах өөрийн гэсэн өвөрмөц арга барилтай, захиргаадаад зандраад байхгүй, эв эеийг нь айтгар олно. Гал тогооны жижүүртэй байхдаа хоолны дараагаар өөрийн ротын цэргүүдийг тусад нь авч үлдээд нэмэгдэл хоол өгч, урлаг, уран сайхнаар идэвхжүүлж, ханын сонин, ухуулагчийн хайрцаг, улс төрийн хичээл, сургалт, хүмүүжлийн ажил, спортын уралдаан тэмцээн гээд захгүй ажил хөвөрч ротын дайчдын чөлөөт цаг, хүмүүжил, ёс суртахууны асуудлыг төвөггүйхэн зохицуулдаг сүйхээтэй эр ээ.

1993 оны намар Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд хадлангийн ажилд цэргүүдтэйгээ ажиллахдаа Баяр ахмадтайгаа хамт явсан минь санаанаас гардаггүй юм. Манай ангиас 5 салаа гарч хоорондоо 10-20 километрийн зайтай хадлангийн бригадуудад хуваарилагдан ажиллахад биднийг ерөнхийд нь удирдахаар Н.Баяр маань томилогдож билээ. Тэр намрын 45 хоногийн хугацаанд Хүдэр сумын Засаг даргаас эхлээд жижүүр, цэвэрлэгч, цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал тэр байтугай Хилийн отрядын дарга нь хүртэл Н.Баярын хуурай дүү нь болсон бөгөөд манай орлогчийн хүнээс гардаггүй байсан юм. Мань хүний хүнтэй харилцах харилцаа нь гайхамшигтай байж билээ. Хатгаа тусаж халуурсан хоёр цэргээ сумын эмнэлэгт нь хэвтүүлж эмчлүүлэх хугацаанд нь засварыг нь хийлгэчихсэн, Хилийн отрядын бие бүрэлдэхүүнд эх орны сэдэвт яриа таниулга хийчихнэ, сургууль, цэцэрлэгийн хичээлийн шинэ жилийн ханын сонин, нээлтийн үйл ажиллагааны найруулга гээд орохгүй ажилгүй л байсан байх. Цэргүүдийн идэх хоол, татах тамхи, халуурч бүлээрч, ханиад хүрэхэд нь өгөх эм тариа бас офицеруудаа баярлуулахаа ч мартаггүй ёстой л хүртээмжтэй эр сэн.

Н.Баяр маань 1995 онд Батальоны улс төрийн орлогчоор дэвшин ажиллаж тэр жилээ БХЯ-ны сайдын үзлэгээр "онц" дүнтэй шалгалтад армидаа үргэлжлүүлэн алба хаах итгэл төгс байсан үедээ үл ялих шалтгаанаар бэлтгэлээр халагдсан даа. Улмаар Төрийн захиргаа, удирдлагын хөгжлийн институтийг төгсөөд Улсын Их Хурлын Тамгын газарт референтээр олон жил ажилласан. Одоо ч бидэндээ улс төрийн орлогч хэвээрээ шүү.

Нэгдүгээр салааны захирагч, ахлах дэслэгч С.Отгонбаяр

Нэгдүгээр салааны захирагч Санжаадоржийн Отгонбаяр нь 1988 онд ЦНДС-ийн Ерөнхий цэргийн "Б" курсийг төгсөж манай ангид хоёр жил ажиллачихсан, Д.Батчулуун бид хоёрын дэргэд туршлагатай салааны захирагч болсон байв. Сонсогч байхдаа надтай нэг ротод хоёр жил амьдарсан, тасгийн дарга, бага түрүүч цолтой, намхавтар нуруутай,

хэр баргийн асуудалд ороод байдаггүй, биеэ зөв авч явдаг, доод курсийн сонсогчдыг дэглэх нь байтугай харьцаад ч байдаггүй эрхэмсэг нэгэн байв. Мань хүн боксоор хичээллэдэг бөгөөд сургуулийн боксын хэд хэдэн удаагийн аварга болсон. Тиймээс Отгонбаяртай маань дээд оньхон нь ч хамаагүй харьцахгүй, өөрөө ч доод курсийнхэнтэй зууралдаад байхгүй тусгаар тогтносон бага түрүүч байв. Хариуцсан салааны цэргүүдээ өөрийн гэсэн удирдах арга барилд оруулсан, түрүүч нартайгаа тулж ажилладаг, хичээлийн конспект, төлөвлөгөө боловсруулах зэрэгт мань хүнээс хуулах, туршлага судлах, авах юм ихтэй. Түүний аав Санжаадорж гуай БХЯ-ны Дайчилгааны газрын дарга, хурандаа цолтой байсан. Тэрээр өөрийн хэрэглэж байсан түргэний чөмоданаа үе уламжлуулан Отгонбаярт өгсөн нь инээдтэй түүх дагуулж билээ. 1990 оны хичээлийн шинэ жил эхлэхийн өмнө 11 дүгээр сарын сүүлээр анги "Цугларалт" дохиогоор ажиллан цугларах байранд гарч аранзанд үзлэг хийж, офицерууд түргэний чөмоданаа шалгуулаад ангийн байрлалд буцаж ирсэн юм. Ротын "канцеляр"-т салбарын офицерууд чөмодан, хувцас хунараа язалж байхад Отгонбаярын чөмоданаас 3 ширхэг "Сарадина" консерв гарч ирлээ. Тэр консервууд нь аль 1972 онд буюу 18 жилийн өмнө үйлдвэрлэгдсэн, "срок годности" нь уже кончилась" болсон эд байв. Бид Отгоогоо цаашлуулан дайсныгаа дайлах хэрэгтэй юм байна гэж маазраад өнгөрөв. Хэд хоногийн дараа чөмоданаас нь өнөөх консервууд алдагдаж, авсан эзэн нь олдохгүй болов. Хэн нь хордож үхэх бол гэж салбарын офицерууд бид хэд хоног түгшсэн ч юу ч болоогүй юм даг. Тэр үед Оросууд ч консервыг хийсэн шиг хийж, цэргүүд ч чонын ходоодтой байх дээ.

Тэрээр хариуцсан салаагаа сайн сургадаг, сахилгын зөрчилгүй удирддаг, салааны эд аж ахуй, зэвсэг, эд хэрэглэлийг бүрэн бүтэн байлгадаг, ангийн тэргүүний салааны захирагч байсан. Анд маань 1993 онд Ардын Армийн 032 дугаар ангид Цэрэг, цагдаагийн тусгай бүлэгт хуваарилагдаад улмаар цомхотголд орж бэлтгэлээр халагдсан юм. Түүнээс хойш С.Отгонбаяр маань Зам гүүрийн бүтээн байгуулалтад дагнан ажиллаж, өөрийн зам гүүрийн бригадтай Тавантолгойн замд ажиллаж байна. Тэрээр Ононгийн гүүрнээс эхлээд олон гүүр, замын хоолойг барьж авто зам гүүрийн бүтээн байгуулалтад гарч бие оролцон амжилт дүүрэн ажиллаж байна.

Гуравдугаар салааны захирагч, дэслэгч Д.Батчулуун

Доржгоочоогийн Батчулуун бид хоёр нэг төгсөлтийнх. Мань хүн онц сурлагатан, сургуулийн номын сангаас салдаггүй, сахилга баттай тэргүүний сонсогч бөгөөд улаан дипломтой, онц төгссөн цөөхөн төгсөгчдийн нэг л дээ. Сургуульд байхдаа бид хоёрын маршрут таардаггүй байсан, цөөхөн тааралдсан санагдана. Харин сургууль төгсөж баяр дээр бидний аавууд тааралдаж нэг нутгийн, нэг голын хүмүүс болохоо мэдэлцсэн сэн. Төгсөөд нэг хороонд нэг ротод хуваарилагдсан нь хувь тавилан гэлтэй. Бид хоёр амьдралын олон нугачаа, саад бэрхшээлийг хамт давж зовлон, жаргалаа хуваалцан 30 гаруй жил нөхөрлөөд байна.

Бид хоёр эсрэг тэсрэг зан чанартай. Тийм болоод ч бие биеэ нөхөөд явдаг байж магадгүй. Манай хүн ажлыг удаагаад байдаггүй газар дээр нь, дор бүр нь хийгээд явдаг гүйцэтгэл сайтай. Шуурхай дайчин зантай. Хэлэх үгээ түс тас хэлчихдэг, нөхөрт тусархуу, мөн толгой сийрэг, тал бүрийн мэдлэгтэй хүн шүү. Хоёрдугаар батальоны улс төрийн орлогч, ахмад Ё.Бямбадорж түүнийг "маневр Батчулуун" гэж өргөмжилдөг байлаа. Анги Сонгинод байхад Улаанбаатар руу өдөрт 2 удаа очихоод оройн нэгдэлтэд хэв нэг зогсож л байдаг сан.

1991 оны хавар Сайдын шалгалтад бэлтгээд Бөхөг түргэний голд хээрийн гаралтад гарчихаад асарт сэвэлзэж

байхад Батчулуун маань лагерийн жижүүртэй үлдээд орой биднийг буудлагаас бууж ирэхэд 4х4-ийн хөвөнтэй майханд тансаг ширээ засчихсан "ноёд офицерууд дээшээ" гэсээр угтаж билээ. Хаврын тарчиг үе, мөн "алдарт 20 дугаар тогтоол" гарчихсан, дэлгүүрт бараа ховордсон хэцүүхэн цагт хээрийн майханд тансаг ширээг Батчулуун л засаж чадсан юм. Энэ өдөр Бөхөгт байрладаг галууны фермээс өндөг авчран майонез зуурч "нийслэл" салат, байцайны салат, галууны өндөгний салат, бууз, хонины тарган хавирга бас хаанаас яаж олсон юм бүү мэд, картанд орсон архийг хүртэл тавьсан тансаг ширээнд сууж дайлуулах таатай байлгүй, яах вэ.

Цэргүүдтэйгээ яг гардаж ажиллана. Биокомбинатын халуун усанд оруулж, салаа цэргийн үсийг "бритв"-ээр өөрийн гараар хусаж, хороонд ганцхан Батчулууны салааны цэргүүд өндөг шиг өөгүй цэвэрхэн байдаг байв. Олны олон дотор ганц нэг цэрэг оргох асуудал гарна. Цэргийн араас явахдаа цэргээ ч олчихсон, биднийхээ ходоодыг халаах шимийн архи, өөрийн амьдралдаа наах тарвага, зурамны арьсны наймааг сүнгэнүүлчихээд ороод ирнэ.

Д.Батчулуун 1993 онд бэлтгэлээр халагдаж хувийн бизнес эрхэлж амжилттай яваа бөгөөд манай ротын гол холбогч нь юм.

1992 онд нэг ротын 3 салааны дарга болох С.Отгонбаяр, Д.Батчулуун бид 3 олны жишгээр наймаа хийхээр Орос руу явж Улаан талбай дээр зургаа авахуулж онож алдаж явсан тухай бичвэл Тансан ламын баруун этгээд зорчсон лугаа адил болох биз ээ.

Шинэ салааны захирагч, дэслэгч Б.Батсайхан

С.Отгонбаяр маань 032 дугаар анги руу Цэрэг, цагдаагийн бүлэг рүү явсны дараа 1993 онд шинэхэн дэслэгч Бямбажавын Батсайхан томилогдон ирж 1 дүгээр салааны захирагчаар ажиллаж эхэллээ. Б.Батсайхан нь намайг 4 дүгээр курст байхад манай ротын 1 дүгээр курст суралцаж байсан залуу байлаа. Курсийнхэн дундаа онцгойдуу нөхөр байсан л даа. Цайвар дугаар царайтай, давхраатай алаг нүдтэй, бахим бие хаатай. Цэргийн нэгдсэн дээд сургууль нь он оны хэлхээс, ахан дүүгийн холбоос, уламжлалыг дамжуулах цувраа юм байна. С.Отгонбаярыг 3 дугаар курст байхад би 1 дүгээр курст, намайг 4 дүгээр курст байхад Батсайхан 1 дүгээр курст байсан бөгөөд төгсөөд нэг салбарт алба хааж, нэг зорилгын төлөө ажиллаж, амьдрах нь ёстой л хувь тавилан юм даа.

Б.Батсайхан маань харин цэргийн дарга, салааны захирагч болох гэж удаан хугацаа зарцуулсангүй, амархан "цагааширлаа". Батсайханы аав Бямбажав гуай Хүндэт харуулын жагсаалын цэргээс ангийн штабын дарга хүртэлх албыг хаасан, ээж Цэенхорлоо нь Армид алба хаах хаахдаа манай ангид бага эмч, ахлах ахлагч цолтой ажиллаж байсан цэргийн даргын гэр бүлд төрж өссөн хүүхэд байсан нь нөлөөлсөн байх.

Салааны цэргүүдээ зандчаад байхгүй ч өөрийн хяналтдаа байлгаж чаддаг, салааны дайчдыг эхийг нь эцээж, тугалыг нь тураалгүй хувцас хэрэглэл, хоол унд, сургалт хүмүүжил, салааны аранз, аж ахуй зэргийг өлхөн аваад явчихдаг айтхар "чөтгөр" болсон билээ. "Түрүүлж ургасан чихнээс сүүлдэж ургасан эвэр урт" гэгчээр сургалт, соёл хүмүүжлийн ажлаар намайгаа хөлдөө чирэхээр салааны дарга болж өссөн дөө. Б.Батсайхан маань намайг 1996 онд армиас бэлтгэлээр халагдах хүртэл ангидаа алба хааж хариуцсан салаагаа онцсайн дүнтэй шалгуулан үр бүтээлтэй ажиллаж байсан. Одоо Онцгой байдлын албаны хурандаа цолтой Нийслэлийн шуурхай удирдлагын төвд Ерөнхий зохицуулагчаар ажиллаж байна.

Батсайхандаа гэр бүлд нь аз жаргал, эрүүл энхийн хүсэн ерөөе. Сайн ажиллаж, сайн яваа дүүгийнхээ сургийг сонсоод ах нь баярлаж явдаг шүү.


Манай ротынхон Ардын Арми, Зэвсэгт хүчинд үүрэг гүйцэтгэж байсан болон одоо хааж буй олон олон төрөл мэргэжлийн ротуудын нэг бөгөөд эх орноо Батлах хамгаалах салбарт алба хааж байсан нөхдөө төлөөлөн дурсамжаа бичлээ.

Цэргийн нөхөрлөл бат бэх байдаг нь бидний ажлын онцлогтой холбоотой байдаг байх. Бидний ажил ашгийн төлөө биш, эх орноо хамгаалах зорилгод нэгдсэн эрчүүдийн нөхөрлөл юм. Иймд урт удаан, бат бэх байдаг бөгөөд цаг хугацааны уртад улам гялалздаг.

Дайчин нөхөрлөл мөнх байх болтугай. Хамт алба хааж байсан эрхэм нөхдөдөө эрүүл энх, саруул сайхныг хүсэн ерөөе.

Монгол Улс мөнх оршиг ээ. Монгол Улсынхаа төлөө зүтгээ.

Бэлтгэл ахлах дэслэгч
Сэнгээгийн ЛХАГВАСҮХ



Дугаарын зочин

Д.Ганхүү: МАРКИЙГ ШҮДТЭЙ, ШҮДГҮЙ ГЭЖ ХОЁР АНГИЛДАГ

Хүн болгон өөрийн гэсэн хоббитой. Тэр ч бүү хэл, зарим нь хоббидоо хөтлөгдөн олон жилийн турш арвин цуглуулгыг бий болгодог. Тэдгээр цуглуулагчдын нэг бол Чингис хаан, Их Монгол Улсын талаарх сэдвээр 2014, 2015, 2016 онд эх орондоо, 2017 онд ӨМӨЗО-ны бүх хотод маркны үзэсгэлэнгээ гаргасан чөлөөнд байгаа ахмад Д.ГАНХҮҮ юм.

Анх хэзээнээс марк цуглуулж эхэлсэн бэ? Яагаад таны сонирхлыг татах болов?

-Би хуучнаар ЗХУ-д Хилийн цэргийн дээд сургуулийг төгсөөд Баян-Өлгий аймгийн Хилийн отрядад маневрын ротын салааны даргын албан тушаалыг хашиж байгаад 1993 онд бэлтгэлээр халагдсан. Тухайн үед Н.Сүхбаатар гэх алдартай цуглуулагч хүн байсан. Марк, тэмдэг, эд хэрэглэл зэрэг янз бүрийн цуглуулгатайгаас гадна өөрөө их гарын үр дийтэй хүн учир олон төрлийн бэлэг, дурсгалын зүйлийг бүтээдэг байв. Монгол Улс 1990 онд зах зээлийн эдийн засагтай ардчилсан нийгэмд шилжин Чингис хаантай холбоотой бүхий л зүйл хаалттай байсан цаг үе дуусахтай зэрэгцэн тэрээр Чингис хаанаар сэдэвлэсэн маркны үзэсгэлэнг гаргасан. Тэгэхдээ уг үзэсгэлэнд орсон материалууд нь харьцангуй бага байсан ч анх удаа маркны үзэсгэлэнг үзсэн надад маш сонирхолтой санагдсан юм. Тэр цагаас хойш марк цуглуулах хоббитой болсон доо. 1990-ээд оны дунд үеэс манай оронд Чингис хаантай холбоотой олон төрлийн марк, ил захидал гарч миний цуглуулга ч тэр хэрээр нэмэгдэж байв. Тэгэхдээ ганц Чингис хааны сэдвээр дагнаж маркаа цуглуулаагүй. Бусад цуглуулагчтай адил Монгол Улсад үйлдвэрлэгдэж байсан бүх цаг үеийн маркийг цуглуулж эхэлсэн. 2000-аад оны эхээр цуглуулга маань нэлээд арвижсан байв. Тэр үед надад нэгэн санаа төрсөн нь Чингис хаан болон түүний үр, ач нар болох Өгөөдэй, Хубилай, Мөнх, Бат хааны холбогдол бүхий



марк, уран зураг, дурсгалын зүйлсээр үзэсгэлэн гаргавал яадаг бол гэсэн бодол байв. Тэгээд л дээрх хаадтай холбоотой бүхий л зүйлсийг цуглуулж эхэлсэн. Гол нь тэр үед би Их Монгол Улсын талаар судалж, мэдсэн зүйл хомс, зүгээр л тэр л сэдэвт хамаарах бүхий л зүйлсийг цуглуулъя гэсэн хөнгөхөн бодолтой байсан хэрэг. Дараахан нь өөрийн цуглуулсан маркуудаар дэлхийн хэд хэдэн оронд үзэсгэлэн гаргаж байсан хүнтэй уулзаж Их Монгол Улсаар сэдэвлэсэн үзэсгэлэн гаргах талаар зөвлөгөө авъя гэж бодоод тусалцаа, дэмжлэг хүслээ. Тэрээр надад "Хэрэв үзэсгэлэн гаргахыг хүсэж байгаа бол зөвхөн "Монгол шуудан" компаниас гарсан ил захидал, дугтуй, марк хүчин төгөлдөр болохоос биш хувийн компанид үйлдвэрлэсэн янз бүрийн зүйлс ордоггүй юм. Чиний цуглуулсан зүйлсээс хэдхэн нь л шаардлагад нийцэж байна. Тэгэхдээ чиний санаа чинь маш зөв" гэж хэлсэн. Тэр цагаас хойш би маркийг дан ганцаар биш иж бүрдлээр нь цуглуулах нь илүү үнэ цэнтэй юм байна гэдгийг ухаарч зөвхөн улсын үйлдвэр, байгууллагад үйлдвэрлэгдсэн марк, ил захидал зэргийг цуглуулах болсон. Энэ байдлаар цуглуулгаа баяжуулсаар Их Монгол Улсын тухай сэдэвлээд

хэд хэдэн удаагийн үзэсгэлэн гаргасан.

Цуглуулагчид дан ганц марк цуглуулдаггүй гэдгийг ойлголоо. Маркнаас гадна ямар материалуудыг нэг сэдэв болгож цуглуулдаг вэ?

-Ер нь маркийг ямар нэгэн сэдвээр багцалж цуглуулах нь хамгийн үнэ цэнтэйгээс гадна хүнд цогц мэдлэгийг өгөх боломжтой учир сонирхолтой цуглуулга болж чаддаг. Нэг сэдэвт багцалъя гэвэл тухайн сэдвийн хүрээнд гарсан марк, ил захидал, анхны өдрийн дугтуй, дугтуйн дээр шуудангаар илгээгдсэнийг нь батлаж тамга, зураачийн эх зураг, эх зургийг зурж байхад гарсан загварууд байвал бүр сайн. Дээрээс нь алдаатай гарсан загварууд олдовол бүр ч үнэ цэнтэйд тооцно гэсэн үг. Мөн маркийг шүдтэй, шүдгүй гэж хоёр ангилдаг. Заримдаа аль алианаар нь ч үйлдвэрлэдэг. Тэр болгоныг нийлүүлэн нэг сэдэвт хамаатуулан цуглуулдаг учиртай.

Чингис хаан, Их Монгол Улсын тухай сэдвээр хэд хэдэн үзэсгэлэн гаргаж байсан гэлээ. Ер нь ийм төрлийн марк хэзээ анх гарч байсан юм бол ...

-Анх манай оронд 1962 онд Их Монгол Улсын сэдвийн хүрээнд Цагаан туг, Гэрэгэ, Чингисийн чулууны бичиг болон Чингис хааны хөргөөр зохиомжилсон

дөрвөн төрлийн марк гарч байсан. Тухайн цаг үед энэ талаар марк гаргах нь битгий хэл, дурсах ч хоритой байсан шүү дээ. Гэвч тэр үеийн эх оронч сэтгэлгээтэй нам, засгийн удирдлагууд энэ сэдвээр марк гаргах талаар хоорондоо зөвшилцөлд хүрч марк, анхны өдрийн дугтуй, ил захидал зэргийг үйлдвэрлэж байсан. Гэтэл дараахан нь ЗХУ-аас энэхүү ажлыг нь бүрэн эсэргүүцэж үйлдвэрлэсэн бүх материалаа устгахад хүрсэн гэдэг. Гэвч цөөн тооны марк, анхны өдрийн дугтуй, ил захидал ард олны дунд хадгалагдан ирснийг би олж аван өөрийн цуглуулгад багтааж чадсан юм. Нэмээд эх зурагны загвар, эх зургийг нь хүртэл олж авсан. Харин 1990-ээд оноос хойш өнөөг хүртэл Их Монгол Улсын сэдэвтэй марк ихээр гарах болсон.

Маркны үнэ цэн юунд оршдог вэ, мөн Монгол Улсын түүх, соёлд ямар ач холбогдолтой вэ?

-Марк бол тухайн орны түүх, соёлын "толь" байдаг. Марк болгон өөр өөрийн түүхийг өгүүлдэг. Өөрөөр хэлэхэд, маркийг зүгээр ч нэг дур мэдэн гаргадаггүй. Заавал түүхэн ойн өдрүүдийг тохиолдуулан шинээр бүтээдэг. Гаргах бүрдээ маш олон төрлийн судалгаа, шинжилгээ хийж, янз бүрийн учир холбогдолтойгоор тухайн маркны зургийг зурдаг. Энэ талаар судлах тусам улсынхаа түүх, соёлын талаар мэдлэгийг олж авдаг ач холбогдолтой. Орчин үед залуучууд маркийг ихээр сонирхож, цуглуулдаг болсон байна. Үүнд би баярлаж явдаг. Энэ бол үр хойчдоо соёлыг үлдээж буй явдал. Нэг ширхэг маркны зураг маш их түүхийг өгүүлж чаддагаараа онцлог. Анх хэн, ямар түүхийн холбогдлыг тусган үзүүлэхийг зорьж энэ бүтээлийг туурвисан бэ гэдгээс нь эхлээд судлах тусам сонирхол татдаг. Би цуглуулгаа аль болох олон хүнд хүргэхийг зорьдог. Эхнэр маань ч гэсэн надтай адил

цуглуулагч. Бид эх орныхоо түүх, соёл, уламжлалыг харуулсан марк, тэмдэг, мөнгөн тэмдэгтийг цуглуулдагаараа үргэлж бахархдаг.

Танай гэр бүл цуглуулгаа тоолж үзсэн үү? Ааж баяжуулдаг вэ?

-Цуглуулагчид өөрсдийн цуглуулгаа тоолдоггүй. Зүгээр л сэдвийнх нь хүрээнд багцалдаг. Монголд үйлдвэрлэгдсэн нийт маркийг 100 хувь гэж үзэхэд 97 хувь нь бидний цуглуулгад бий. 1924 онд Ардын засгийн газрын түшмэл Бат-Очир гэдэг хүний санаачилгаар "марзан" Б.Шарав зургийг нь зуран хэвлүүлсэн "Элдэв-Очир" нэртэй марк нь манай орны хамгийн анхных гэж тооцогддог. Түүнээс хойш нийт 1064 сэдвийн марк гарсан. Тэдгээрээс 20 хүрэхгүй сэдвийн марк л бидний цуглуулгад байхгүй. Ерөнхийдөө 1958 оноос хойш гарсан бүх маркийг цуглуулсан гэж хэлж болно. Бид "Монгол шуудан" компаниас шинээр гаргасан маркыг цаг алдалгүй худалдаад авчихлаа гэж бодоход өөрт байхгүй ховор марк болон тэр сэдэвт багтах бусад материалыг олж авах хэцүү. Заримдаа ерөөсөө олдохгүй үе гарна, олдохдоо асар өндөр үнээр олдоно. Тэр үед мөнгөө харамлалгүй худалдаж авахыг л боддог доо.

Залуу цуглуулагчдад юу гэж захиж вэ?

-Залуу хүн аливаа зүйлийг шимтэн судалдаг байх ёстой. Тэр тусмаа Монгол Улсынхаа баялаг түүхийг мэддэг байх хэрэгтэй. Миний хувьд маркаар дамжуулан соёл, уламжлалынхаа талаар судалдаг шиг залуучууд ямар нэгэн цуглуулгатай болж үүгээрээ гадаадын олон улс оронд үзэсгэлэн гаргаж, эх түүхээ бусдад таниулах хэрэгтэй л гэж захимаар байна. Марк бол тусгаар тогтносон улсын бэлэг тэмдэг. Монгол гэдэг тусгаар улс байдаг юм шүү гэдгийг тив, дэлхийд мэдрүүлэх хэрэгтэй.

Дэд ахлагч Т.ИДЭР

ЭМГЭНЭЛ

ЧИМЭДИЙН ДАШЖИВАА (1952-2020)



Чөлөөнд байсан хурандаа Ч.Дашживаа хүнд өвчний улмаас 2020 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр хорвоогийн мөнх бусыг үзүүлж бидэнд нөхөж баршгүй уй гашуу тохиолоо.

Чимэдийн Дашживаа 1952 оны 12 дугаар сарын 27-ны өдөр Дорноговь аймгийн Мандах суманд төрсөн. Бага насаа эцэг, эхийн гар дээр өнгөрүүлж, 1960-1964 онд сумын бага сургууль, 1964-1968 онд Зүүнбаянгийн 10 жилийн дунд сургууль, 1968-1972 онд Улаанбаатар хотын Барилгын техникум, 1977-1982 онд Политехникийн дээд сургуулийг төгсөж, Барилгын техникч, инженер мэргэжил эзэмшсэн.

Тэр бээр 1972-1973 онд Улаанбаатар хотын Барилгын зургийн товчоонд Зургийн инженер, 1973-1974 онд Ардын Армийн 135, 144 дүгээр ангид түрүүч, Салааны захирагч, Барилгын техникч, 1974 оноос Ардын Армийн

Ар талыг удирдах газар, Зэвсэгт хүчний Жанжин штабын Барилгын материалын инженер, Зураг төсвийн товчооны дарга, Ерөнхий инженер, Хэлтсийн дарга, Газрын орлогч дарга зэрэг албан тушаалд үр бүтээлтэй ажиллаж байгаад 2005 онд цэргийн тэтгэвэрт гарсан юм.

Хурандаа Ч. Дашживаа хэдийгээр цэргийн тэтгэвэрт гарсан боловч Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний бүтээн байгуулалтын үйл ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэх болоод залуу хойч үеэ сургаж бэлтгэх үйлсэд үнэлж баршгүй хувь нэмрээ оруулсан хөдөлмөрч нэгэн байлаа.

Тэрээр 2005-2015 онд Батлан хамгаалах яамны Барилга захилагчийн албанд Барилга угсралтын ажлын хяналтын инженерээр ажиллаж, эзэмшсэн мэргэжил, дадлага туршлагаа ашиглан Энхийг сахиулагчдын нөхөн сэргээх амралт, сувиллын цогцолбор төв, Зэвсэгт хүчний 084, 089, 232, 325 дугаар ангийн байрлалд баригдсан албан тушаалын орон сууц, БХЯ, ЗХЖШ-ын ажилтнуудын зуслангийн барилгууд, Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн Говийн бүсийн Сургалтын төв, Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн Цэргийн нисэх буудал, Зэвсэгт хүчний 331, 350 дугаар ангийн шинэ бүтээн байгуулалтын ажлуудыг

хэрэгжүүлэхэд идэвх, зүтгэл, санаачилгатай ажиллаж байсан юм. Тэрчлэн Батлан хамгаалах салбарын хэмжээнд шинээр ашиглалтад орсон бусад олон арван барилга байгууламжийн зураг төсөл, их засвар, угсралтын ажлын явцад оролцон мэргэжлийн хяналт тавьж, ашиглалтад чанарын өндөр түвшинд хүлээлгэн өгсний зэрэгцээ Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнийг ажиллаж, амьдрах ая тухтай нөхцөл, боломжоор хангах үйлсэд бүтээлч хувь нэмрээ оруулж байлаа.

Хурандаа Ч.Дашживаагийн улс, эх орон, Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний бүтээн байгуулалтын үйл хэрэгт оруулсан их хувь нэмэр, мэдлэг, ур чадвар, туршлага, хичээл зүтгэлийг нь төр, засгаас өндрөөр үнэлж Цэргийн гавьяаны улаан тугийн одон, Цэргийн гавьяаны одон, Цэргийн хүндэт медаль, Хөдөлмөрийн хүндэт медаль болон бусад ойн медалиар шагнаж, Тэргүүний барилгачин, Аж үйлдвэрийн тэргүүний ажилтан цол, тэмдгийг хүртээсэн юм.

Түүний гэгээн дүр төрх, хүнлэг, нинжин сэтгэл, хийж бүтээсэн нь болон хийхээр зорьсон их хүсэл, тэмүүлэл нь бидний зүрх сэтгэлд өнө мөнхөд орших болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Г.САЙХАНБАЯР, БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА, ХУРАНДАА Д.ГАНХУЯГ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН ДАРГА, ХОШУУЧ ГЕНЕРАЛ Д.ГАНЗОРИГ, БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ НИЙТ БИЕ БҮРЭЛДЭХҮҮН

СЭРЭЭНЭНГИЙН ДОНДОГДОРЖ (1949-2020)



Бидний дотны нөхөр, ахмад дайчин, инженерийн цэргийн нэрт захирагч, дарга нарын нэг хурандаа С.Дондогдорж нь 2020 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр хүнд өвчний улмаас ертөнцийн мөнх бусыг үзүүлж бидэнд нөхөж баршгүй хүнд гарз тохиолоо.

Хурандаа С.Дондогдорж монгол цэргийн шилдэг уламжлалаа дээдэлдэг, цэргийн хэргийн өндөр боловсролтой, шулуун шударга, зарчимч, эх оронч, алсын хараатай, аливаад нягт нямбай, ажилсаг хичээнгүй, хөдөлмөрч, хүнлэг сайхан сэтгэлтэй, энэрэнгүй нэгэн байлаа. Тэрээр 1949 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр Улаанбаатар хотод мэндэлж, 1956-1966 онд дунд сургуульд суралцаж төгссөн ба цэргийн албанд татагдан, улмаар ЗХУ-ын Калининград хотын А.А.Ждановын нэрэмжит Цэргийн инженерийн дээд сургуулийг 1971 онд, ЗХУ-ын Москва хотын В.В.Куйбышевын нэрэмжит Цэргийн инженерийн академийг 1982 онд тус тус амжилттай төгсөж цэргийн инженерийн дээд боловсролыг эзэмшсэн юм.

Тэр бээр томилогдсон хороо, анги, салбарынхаа ажлыг цаг ямагт чадварлагаар удирдан зохион байгуулж, залуу хойч үедээ өөрийн мэддэг, чаддаг бүхнээ харамгүй зааж сурган эх орондоо чадварлаг эрсийг бэлтгэж байсны сацуу улс орныхоо батлан хамгаалах болон инженерийн цэргийн хөгжил, дэвшилд жинтэй хувь нэмрээ оруулсан зүтгэлтэн байлаа.

Түүний нэр их хөдөлмөр, зүтгэлийг төр, засгаас өндрөөр үнэлж Цэргийн гавьяаны одон, Цэргийн хүндэт медаль болон бусад ойн медалиар шагнажээ. Түмэндээ нэртэй, олондоо хүндтэй явсан таны ухаарал, урам хайрласан үг, халуун дулаан нийэмсэглэл, зааж сургасан бүхэн, гэгээн дүр төрх тань бидний зүрх сэтгэлд үүрд мөнх хоногшин үлдэх болно.

"ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙН ХОЛБОО" ТББ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 014 ДҮГЭЭР АНГИЙН ХАМТ ОЛОН, МАА-ИЙН 199 ДҮГЭЭР АНГИЙН АХМАДУУД, ГЭР БҮЛ, ҮР ХҮҮХЭД, ТӨРӨЛ ТӨРӨГСӨД, АНД НАЙЗУУДААС НЬ



ХАДЫН БАДРАА (1935-2020)

Чөлөөнд байсан хошууч, улс төр, соёлын ахмад ажилтан Х.Бадраа 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр өвчний улмаас таалал төгссөнд талийгаачийн гэр бүл, үр хүүхдүүд, төрөл төрөгсдөд гүн эмгэнэл илэрхийлж байна.

Тэрээр 1935 онд Төв аймгийн Баян-Өндөр суманд төрсөн. Бага насаа эцэг, эхийн гар дээр өнгөрүүлж, улмаар бага, дунд сургууль дүүргэсэн ба 1968 онд ЗХУ-ын Львов хотын Цэргийн дээд сургуулийг Цэргийн улс төр, соёлын ажилтны мэргэжлээр төгссөн юм.

Х.Бадраа нь Ардын Армиуд 30 гаруй жил үр бүтээлтэй ажилласны дотор 1952-1962 онд Ардын Армийн Дуу Бүжгийн Ансамбльд бүжигчин, 1978-1988 онд тус ансамблийн ар талын орлогчоор 10 гаруй жил ажилласан бөгөөд энэ хугацаанд цэргийн алба хаагч, уран бүтээлчдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд онцгой анхаарч, ансамблийн гадаад орнуудад айлчлан тоглох тоглолтын бүхий л бэлтгэлийг хангахад идэвх зүтгэлтэй ажиллаж, цэргийн дүрэмт хувцас, тоглолтын хувцасны хангалтыг өнгө үзэмж, чанар сайтай нийлүүлсэн нь гадаад, дотоодын үзэгчдээс өндөр үнэлэлтийг авахад чухал үр нөлөөтэй ажил байлаа. Улмаар Офицеруудын ордны гадна, доторх тохижилт, өнгө үзэмж, уран бүтээлчдийн ажиллах нөхцөлийг сайжруулах, нэгтгэл, ангиудын офицер, ахлагч нарт урлаг, соёлоор үйлчлэх тохилог орчинг бүрдүүлэхэд бүхий л хүч хөдөлмөрөө зориулан ажиллаж байсан юм.

Талийгаачийн гавьяа зүтгэл, хөдөлмөрийг төр, засгаас өндрөөр үнэлэн Цэргийн гавьяаны улаан тугийн одон, Цэргийн гавьяаны одон, "Алтан гадас" одон, Цэргийн хүндэт медаль болон бусад ойн медалиудаар шагнасан юм.

Эрхэм таны дөлгөөн, хүнлэг энэрэнгүй, ажилч хичээнгүй, бүтээлч зан чанар бидний зүрх сэтгэлд үүрд хоногшин үлдэх болно.

ЦЭРГИЙН ДУУ БҮЖГИЙН ЭРДИЙН ЧУУЛГЫН УДИРДЛАГА, ХАМТ ОЛОН, АХМАДЫН ХОРОО

СОЁМБО СОНИН
"Соёмбо" сонин 96 дахь жилдээ хэвлэгдэж байна.
Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА,
Д.НАЦАГДОРЖ

Эрхлэгч
Хурандаа
Батжаргалын
ОТГОНБАЯР

Эхийг "Соёмбо" сонин
релаксад бэлтгэж,
"Соёмбо принтинг" хэвлэх
үйлдвэрт хэвлүүлэв.

*Зар, рекламныг хямд нийтэлнэ.
*Зар, рекламны үнэ зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.
*Зохиогчийн үзэл бодол сонин нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.
*Тус сонин мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон
Индекс 10018
И-мэйл хаяг:
Mil_newssoyombo@yahoo.com
Утас: 70001029